АГУУЛГА

1. Дорноговь аймгийн алтанширээ сумын нутаг дэвсгэрт “газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн товч танилцуулга 2
1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл 2
1.2 Төслийн талаарх товч мэдээлэл 3
1.2.1 Төслийн зорилго 3
1.2.2 Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага 3
1.2.3 Төслийн үндсэн мэдээлэл 12
1.2.4 Төслийн хууль эрхзүй, бодлогын суурь баримт бичиг 12
1.2.5 Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж 13
1.2.6 Төсөл хэрэгжих газар нутгийн байршил 13
1.2.7 Газрын тос боловсруулах үйлдвэр /ГТБҮ/-ийн гол байгууламж 14
1.2.8 ГТБҮ-ийн үндсэн байгууламж 15
1.2.9 ГТБҮ-ийн дагалдах байгууламж 15
1.2.1 ГТБҮ-ийн дэд бүтэц 15
1.2.1 Төслийн технологи 15
1.3 Төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл 16
1.3.1 Төслийн ерөнхий мэдээлэл 16
1.3.2 Төслийн суурь судалгааны ажил 16
1.3.3 Төслийн дэд бүтцийн ажлын явц 16
1.3.3 Төмөр зам 17
1.3.4 Үйлдвэрийн усны эх үүсвэр, ус хангамжийн шугам хоолойн барилга, байгууламжийн ажил 18
1.3.5 Газрын тосны үйлдвэрийн хотхоны барилга, байгууламжийн ажил 19
1.3.6 Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 19
1.3.7 Төслийн байгаль орчны холбогдолтой тайлан, материалууд 21
2 Дорноговь аймгийн сайншанд, алтанширээ сумдын байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт 23
2.1 Физик газарзүйн нөхцөл ....***Error! Bookmark not defined.***
2.2 Уур амьсгал ....***Error! Bookmark not defined.***
2.3 Газрын доорх ус *37*
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт 48
3.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ 50
Хамрах хүрээ ....***Error! Bookmark not defined.***
3.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө *32*
3.1.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө *35*
3.1.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө *36*
3.1.3 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 37
3.1. 4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө *39*
3.1.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 41
3.1.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө *44*
3.1.7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах төлөвлөгөө *45*
3.1.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал ***Error! Bookmark not defined.***
4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 49

1. ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЛТАНШИРЭЭ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ “ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн хүрээнд 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар тогтож “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК /МГТБҮ ТӨХХК/-ийг үүсгэн байгуулсан.

Засгийн газрын 92 дугаар тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 92

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн хүрээнд 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар тогтсугай.

2. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо, судалгаанд тулгуурлан энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан компанийг үүсгэн байгуулах ажиллагаа болон бүтэц, зохион байгуулалт, дүрмийг боловсруулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн санхүүжилт, холбогдох бусад зардалд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга — Ж.МӨНХБАТ


Аж ахуйн нэгжийн гэрчилгээ


МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
6001177061
2017.04.25 — 9011671052
6177492
Монгол газрын тос боловсруулах үйлдвэр — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Дүрэм
Төгтоол — 108 — 2017.04.04
6299 — "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлах
Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Бага тойруу, Сүхбаатарын талбай гудамж 8/1 байр 1601 тоот, Утас1 88007340, Утас2: , Факс:
Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
Гэрчилгээ дахин олгосон 2018 он 12 сар 20 өдөр

МГТБҮ ТӨХХК-ийн бүтцийг 2021 онд шинэчилж, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 01 дүгээр тогтоолоор батлагдсан. Манай компани газрын тос боловсруулах үйлдвэрийн төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн ашиглалтын бүх үе шатанд хүний эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, үйл ажиллагааг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгалийн болон түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах бодлогыг баримталж ажиллах бөгөөд байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал

хариуцсан нэгж Байгаль орчин, хөдөлмөр хамгааллын алба нь дарга 1, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн 1, харуул хамгаалалт хариуцсан ахлах ажилтан 1, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн 1, буюу 4 орон тоотойгоор ажиллаж байна. Зураг 1-ээр компанийн бүтэц, зохион байгуулалтыг харуулав.

Зураг 1: “МГТБҮ” ТӨХХК-ийн бүтэц



“МГТБҮ”

ХХК-ийн холбоо барих хаяг:

Регистрийн дугаар: 6177492
Улсын бүртгэлийн дугаар: 9011671052
Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-3, Бодь цамхаг, 900 тоот
Утас: 00-976-70100389, 00-976-70100390
И-мэйл хаяг: info@mongolrefinery.mn
Вэбсайт: www.mongolrefinery.mn

1.2 ТӨСЛИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Төслийн зорилго

Дотоодын түүхий эдийн нөөцөд түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, Монгол улсын түлш шатахууны хэрэгцээг ханган, нефть-химийн үйлдвэрийн суурийг тавьж, эдийн засагт хүч нэмэх шинэ аж үйлдвэрийг цогцоор нь бүтээн байгуулахад оршино.

1.2.2 Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Сүүлийн жилүүдэд уул уурхай, газар тариалангийн салбар эрчимжиж, хотжилт төвлөрөлтөөс үүдсэн авто тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор манай орны газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ тогтмол өссөөр байна. Өнгөрсөн 5 жилийн байдлаар гадаад улсаас жилд дунджаар 1,25 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн худалдан авч, 1,0 тэрбум орчим ам.доллар зарцуулсан нь нийт импортын 25-30%-ийг эзэлж байна. Манай улсын хувьд автобензиний хэрэглээний дийлэнхийг суудлын автомашин, нийтийн тээврийн хэрэгсэл эзэлдэг бол дизель түлшний дийлэнхийг ачаа тээвэр, уул

уурхай, газар тариалангийн хүнд машин механизмд хэрэглэж байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн нийт зардлын 30 орчим хувийг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нийт зардлын 25-30 хувь нь түлш шатахууны зардал байдаг. Манай улсын хувьд газрын тосны бүтээгдэхүүний импортоос 100 хувь хараат байгаа нь гадаад худалдааны тэнцэлд муугаар нөлөөлөхөөс гадна бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, инфляцийг хөөрөгдөх гол хүчин зүйл болохын зэрэгцээ иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, улс орны хөгжлийн бодлого, эдийн засгийн аюулгүй байдалд хүндрэл учруулж байна.

Манай улсын газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа 2005 оноос эхлэн эрчимжсэнээр газрын тосны батлагдсан нөөцтэй болж, үйлдвэрлэлийн олборлолтыг 2010 оноос эхлүүлж, өнөөгийн байдлаар олборлосон тосоо БНХАУ-д экспортолж байна. “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн хүчин чадлыг 2012 онд Газрын тосны газар (хуучин нэрээр)-ын Хайгуул, ашиглалтын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тус газрын даргын 125 дугаар тушаалаар батлуулсан “Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан түүхий тосны олборлолтын төлөвлөгөөнд суурилан 1,5 сая тонн байхаар төлөвлөсөн. Хүснэгт 2-оор Монгол улсын газрын тосны нөөц, Хүснэгт 3-аар газрын тосны баталгаат нөөцийн талаар тус тус харуулав.

Хүснэгт 1: Монгол улсын газрын тосны нөөц


ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦ - 2010	
Газрын тосны ордууд	**Баталгаат нөөц (сая.тн)**
Тосон – Уул XIX	179,6
Тамсаг – XXI	127
Цагаан – Элс – XIII	26
НИЙТ	**332,6**

Хүснэгт 2: Газрын тосны баталгаат нөөц

ГАЗРЫН ТОСНЫ БАТАЛГААТ НӨӨЦ	
Баталгаат нөөц (сая.тн)	**Ашиглалтын баталгаат нөөц (сая.тн)**
332,6	**43,2**
	Тосон – Уул XIX – 20,2
	Тамсаг – XXI – 21,01

Мөн газрын тосны хайгуулын Матад XX, Хөхнуур XVIII болон Галба XI талбайгаас тос илэрсэн тул хайгуул, туршилтын ажлыг эрчимжүүлж, шинээр орд болгон хөгжүүлж, нөөцийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Зураг 2: Монгол улсын газрын тосны хайгуул, ашиглалтын талбай


MONGOLIA
ULAANBAATAR
I
II
III
IV
V
VI
VII
VII
IX
X NORTH
X SOUTH
XI
XII
XIII
XIV
XV
XVII
XVIII
XIX
XX
XXI
XXII
XXIII
XXIV
XXVI
Petro China
Petro Matad
China Golden Sea Petroleum
Dongsheng Gazriin Tos

1.2.3 Төслийн үндсэн мэдээлэл

Хүчин чадал:	Жилд 1,5 сая тонн газрын тос боловсруулах
Үйлдвэрийн байршил:	Дорноговь аймаг, Алтанширээ сум, 3-р баг
Боловсруулах тос:	Газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX & Тамсаг-XXI талбайн тосны холимог
Бүтээгдэхүүний чанар:	Монгол улсын болон Евро V стандартад нийцсэн
Жилд ажиллах хугацаа:	8000 цаг (8750 цаг ажиллах боломжтой)
Гүн боловсруулалтын технологи:	Гидрокрекинг
Үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн:	43 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий 339 мянган тонн авто бензин 824 мянган тонн дизель түлш 80 мянган тонн онгоцны түлш 47 мянган тонн зуухны түлш

Хүснэгт 3: Үйлдвэрээс гарах бүтээгдэхүүний төрөл

Бүтээгдэхүүн	Хэмжээ (тонн)	Нягт (кг/м3)	Эзэлхүүн (л)
ШШХ	43 000	746	57 641 000
АИ-95 бензин	339 000	750	452 000 000
Онгоцны түлш	80 000	788	101 523 000
Дизель түлш	824 000	840	1 008 905 600
Зуухны түлш	47 000	1.015	46 305 000
Нийт	**1 333 000**		**1 635 279 000**

1.2.4 Төслийн хууль эрхзүй, бодлогын суурь баримт бичиг[1]

Монгол Улс өнөөдрийг хүртэл газрын тос боловсруулах үйлдвэр барьж, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ хангах бодлогыг баримталсаар ирсэн бөгөөд үе үеийн Засгийн газар мөрийн хөтөлбөртөө тусгаж, түүний дагуу дараах хууль эрхзүй, бодлогын баримт бичгүүдийг гаргасан. Үүнд: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 14/06 дугаар “Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах” тухай зөвлөмж; Засгийн газрын 2015 оны 113 дугаар “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоол, (Урьдчилсан ТЭЗҮ-ийг Унгар улсын Euro Oil компани боловсруулсан); Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.70-д “Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах”-аар тусгагдсан; Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай” 59 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэхээр тогтсугай; БНЭУ-ын Экспорт-Импортын банкны 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдөр УИХ-аас соёрхон баталсан; Ерөнхий сайдын 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар захирамжаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэх 100 хувь төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах, бүтэц, зохион байгуулалт, дүрмийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан; Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 92 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэж,

[1] Эх сурвалж: www.legalinfo.mn

ТӨБЗГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хариуцлагатай хязгаарлагдмал компанийг байгуулсан; Засгийн газрын 2017 оны 163 дугаар “Нарийвчилсан ТЭЗҮ-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тухай” тогтоол; Тендерт шалгарсан “БНЭУ-ын Инженерс Индиа Лимитэд /Engineers India Limited/ компанитай Нарийвчилсан ТЭЗҮ хийх Зөвлөх үйлчилгээний гэрээ”-нд 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдөр гарын үсэг зурсан; Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “Монгол улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжид, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх” гэж тусгагдсан; Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 2 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэрийн гаднах дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн; ТӨБЗГ-аас 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор үйлдвэрийн гаднах дэд бүтцийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх талаар Хөгжлийн банктай зээлийн гэрээ байгуулахыг зөвшөөрсөн; Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчийг томилж, дэд бүтцийг барьж байгуулах тухай тогтоол;

Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Үйлдвэрийн газрыг тусгай хэрэгцээнд авах тухай” 28 дугаар тогтоол;

1.2.5 Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж

Бүх төрлийн татвар болон ногдол ашгаас улсын төсөвт томоохон хувь нэмэр оруулна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 гаруй хувиар нэмэгдүүлнэ.Монголын эдийн засаг түлш шатахууны хараат байдлаас гарна.Гадагш гарах валютын урсгал буурна.Улс орны нийт эдийн засагт шинэ салбар бий болж, цогц аж үйлдвэрийн хөгжлийн чухал элемент болох нефть-химийн үйлдвэрийн суурь тавигдана. Монгол улс өөрийн гэсэн эрчим хүчний шинэ бааз суурьтай болно.Газрын тосны олборлолт, тээвэрлэлт, боловсруулалтыг дагаад эдийн засгийн бусад салбарууд хөгжинө.Шууд ба шууд бус байдлаар ажлын байр олноор бий болно.“Сайншандын Аж үйлдвэрийн парк”-ийн суурь тавигдаж, техник, технологийн шинэ төв бий болно. Орчин цагийн аж үйлдвэрийн хөгжилтэй хөл нийлүүлэх боломж бий болно.

1.2.6 Төсөл хэрэгжих газар нутгийн байршил

Газрын тос боловсруулах үйлдвэр нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших ба Улаанбаатар хотоос зүүн урагш 430 км-т, аймгийн төв Сайншанд хотоос зүүн хойш 20 км-т, Алтанширээ сумын төвөөс урагш 60 км-т байрлана. Монгол орны байр зүйн зургийн “L-49-101, L-49-113” дугаар хавтгайнуудын зааг дээр оршдог. Төслийн талбай нь Монгол Улсын Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13 дахь заалтын дагуу “улсын тусгай хэрэгцээний газар”-т хамаарах бөгөөд 405 га талбайг хамарна

1.2.7 Төслийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК (МГТБҮ) нь Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан 100 хувь төрийн өмчит компани юм. МГТБҮ нь Дорноговь аймгийн Алтанширээ суманд жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг барьж байгуулж буй бөгөөд тус үйлдвэрийг 2028 оноос ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Үйлдвэрт шаардагдах түүхий тосны тасралтгүй, найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст-XXXI талбайг МГТБҮ-д олгосон.

Давст-XXXI талбай нь Тамсагийн сав газарт оршиж, нийт 15,528 км² талбайг хамарна. Тамсагийн сав газарт өмнөх гэрээлэгчид 2007–2009 онд 69 хайгуулын цооног өрөмдсөн. МГТБҮ-ийн 2025 оны урьдчилсан хээрийн үзлэгээр 9 цооногийн амсарт тос, хий шүүрч буй шинж тэмдэг тэмдэглэгдсэн боловч 69 цооног тус бүрийн дугаар, солбицол, техникийн өнөөгийн төлөв, фото баримт бүхий нэгдсэн бүртгэл энэ тайланд ирүүлэгдээгүй. Иймээс

өрөмдлөг эхлэхээс өмнө бүх 69 цооногт нэг бүрчилсэн үзлэг хийж, шүүрэлттэй цооногуудын нэр, дугаар, солбицол, битүүмжлэл, бохирдлын хүрээ, фото зураг, хөрс–ус–NORM-ийн шинжилгээний дүнг хавсралтаар баталгаажуулна. Энэхүү БОННҮ нь 2026–2033 оны хайгуул, үнэлгээний хөтөлбөрийг хамарна.

Зураг 3: Төслийн талбайн байршлын тойм зураг

1.2.8 Газрын тос боловсруулах үйлдвэр /ГТБҮ/-ийн гол байгууламж



ТЕХНОЛОГИЙН БАЙГУУЛАМЖУУД



АГУУЛАХ САВ, РЕЗЕРВУАРУУД



АЧИХ, БУУЛГАХ БАЙГУУЛАМЖ



ҮЙЛДВЭРИЙН ЦАХИЛГААН СТАНЦ



УС ДАМЖУУЛАХ ШУГАМ ХООЛОЙ



ТҮҮХИЙ ТОС ДАМЖУУЛАХ ХООЛОЙ

1.2.9 ГТБҮ-ийн үндсэн байгууламж

- Энгийн болон вакум нэрлэгийн байгууламж
- Дизель гидроцэвэрлэгээ (керосин болон амин цэвэрлэгээ)
- Нафта гидроцэвэрлэгээ (амины цэвэрлэгээ)
- Риформинг
- Изомержүүлэлт
- Висбрекинг
- Гидрокрекинг
- Устөрөгч үйлдвэрлэл
- Хий ялгах (хий цэвэрлэх хэсэг)
- Амин ялгах
- Хүхэр үйлдвэрлэх
- Ус цэвэршүүлэгч
- Таваарын бүтээгдэхүүн бэлтгэх дамжлага

1.2.10 ГТБҮ-ийн дагалдах байгууламж

- Түүхий тос хүлээн авах байгууламж, хадгалах сав
- Завсрын бүтээгдэхүүний хадгалах сав
- Эцсийн бүтээгдэхүүний хадгалах сав
- Бүтээгдэхүүн холих байгууламж
- Бүтээгдэхүүн ачих байгууламж
- Бамбарын систем
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Цэвэр усны хангалтын систем
- Түүхий тос хүлээн авах байгууламж

1.2.11 ГТБҮ-ийн иргэний байгууламж

- Үйлдвэрийн захиргаа
- Ажилчдын хоолны газар
- Эмнэлгийн төв
- Сургалтын төв

ГТБҮ нь нийт 560 орчим боловсон хүчинтэйгээр өдөрт 3 ээлжээр ажиллахаар төлөвлөсөн бөгөөд үйлдвэрийн захиргаа, ажилчдын хоолны газар, эмнэлгийн төв, сургалтын төв зэрэг байгууламжууд нь өдөрт 180-200 хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай бөгөөд ногоон байгууламж, авто зогсоолтой байхаар төлөвлөгдсөн.

1.2.12 МГТБҮ-ийн дэд бүтэц

1.2.12.1 Цахилгаан хангамж

1.2.12.2 Хүнд даацын авто зам

1.2.12.3 Төмөр зам

1.2.12.4 Усны эх үүсвэр, ус хангамжийн шугам хоолой

1.2.13 Төслийн технологи

НТЭЗҮ-д нийт 9 технологийг харьцуулан үзсэний үндсэн дээр Монгол улсын газрын тосны шинж чанар болон эдийн засгийн үр өгөөжийн тооцооноос хамаарч ҮШКК болон ГКБ+ВБ гэсэн хоёр төрлийн технологийг тохирно гэж тодорхойлсон. Нарийвчилсан ТЭЗҮ-ийн шийдэлд үндэслэн Монгол талаас газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн ГКБ+ВБ–ийн хувилбарыг сонгохоор шийдсэн. Мөн түүхий эдийн сонголтыг хийхийн тулд 2 төрлийн түүхий тосны харьцуулсан судалгааг хийж, сонголтыг хийсэн.Төсөлд тусгагдсанаар дизайн түүхий тос 1 буюу Тосон уул-XIX ба Тамсаг-XXI ордын тосны холимгийн жингийн 50:50% (Монгол улсын түүхий тос 3–Интертек шинжилгээ) тосыг боловсруулахаар сонгон авсан.

1.3 ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1.3.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-аас газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл (НТЭЗҮ)-ийг боловсруулах Зөвлөхөөр БНЭУ-ын төрийн өмчит “Engineers India Limited” (EIL) компанийг 2017 оны 4 дүгээр сард сонгон шалгаруулж, НТЭЗҮ-д хяналт тавьж, дүгнэлт гаргах “Захиалагчийн инженер”-ийн зөвлөх компаниар Итали улсын КТ-Кинетикс Текноложи компанийг шалгаруулсан. 2018 оны 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар НТЭЗҮ-ийг батлуулж, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлснээр “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төсөл эрчимжсэн. 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт газрын тос боловсруулах үйлдвэрийн шав тавих ёслолын ажиллагаа болж, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БНЭУ-ын Дотоод хэргийн сайд ноён Ражнат Сингх болон бусад холбогдох албаны хүмүүс оролцсон. БНЭУ-аас авах хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийн дагуу Төслийн менежментийн зөвлөхийг тус улсын Экспорт-Импортын Банкны урьдчилсан сонгон шалгаруулалтаар “Engineers India Limited” (EIL-ийн линк) сонгогдон, Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр байгуулж, инженерийн ерөнхий зураг төсөл боловсруулах ажил эхэлсэн. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” цогц төсөл нь үйлдвэрийн үндсэн технологийн байгууламжуудаас гадна иргэний байгууламж, цахилгаан станц, усны эх үүсвэр усан хангамжийн байгууламж, ачих буулгах байгууламж, агуулах сав, резервуурууд, түүхий тос дамжуулах хоолой, төмөр зам, хүнд даацын авто зам, газрын тосны үйлдвэрийн хотхон зэргээс бүрдэнэ.

1.3.2 Төслийн суурь судалгааны ажил

- Гүнийн геофизик болон геотехникийн судалгаа;
- Хэт том оврын ачааг тээвэрлэх судалгаа;
- Үйлдвэрийн усны эх үүсвэр ба ус хангамж, ус дамжуулах шугам хоолой барих трассын болон хөрсний судалгаа;
- Газрын тос дамжуулах хоолойн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ;
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;
- Үйлдвэрийн усны эх үүсвэр ба ус хангамж, ус дамжуулах шугам хоолойн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;
- Төмөр замын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;
- Археологи, угсаатны зүйн урьдчилсан хайгуул, судалгаа;
- Палеонтологийн урьдчилсан хайгуул, судалгааны ажлууд тус тус багтана.

1.3.3 Төслийн дэд бүтцийн ажлын явц

1.3.3.1 Цахилгаан хангамж

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн барилгын ажлын үеэр ойролцоогоор 3.5 МВт эрчим хүч хэрэглэхээр тооцсон. Газрын тос боловсруулах үйлдвэр нь цахилгаан, дулаан, уурын хэрэглээгээ хангах зорилгоор өөрийн 35 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцтай байхаар төлөвлөгдсөн. Үйлдвэрийн цахилгаан станц нь тус бүр нь 17.5 МВт-ын хүчин чадалтай 2 иж бүрдэл уурын турбин генератор, 200 тн/цаг хүчин чадалтай ажлын 1, нөөц 1, нийт 2 иж бүрдэл хэрэглээний бойлертой байна. Мөн уурын хэрэгцээг хангах зорилгоор зөвхөн өвлийн улиралд асаах, унтраах үед шаардлагатай 50 тн/цаг хүчин чадалтай хэрэглээний бойлертой байна. Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ерөнхий гүйцэтгэгчээр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК ажилласан бөгөөд гэрээт ажлыг 2019 оны 7 дугаар сарын 05-нд Улсын коммисст хүлээлгэн өгсөн.

Зураг 4: Цахилгаан дамжуулах агаарын шугам





1.3.3.2 Хүнд даацын авто зам

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь 2024 он хүртэл үе шаттайгаар хэрэгжих бөгөөд дэд бүтэц, газрын тосны үйлдвэрийн хотхон, иргэний барилга байгууламж болон үйлдвэрийн дагалдах, үндсэн байгууламжуудын барилга, угсралтын ажлын үед хүнд даацын авто машин зорчих, техник тоног төхөөрөмж их хэмжээгээр тээвэрлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Сайншанд сумаас үйлдвэрийн талбай хүртэл 17.5 км бөгөөд авто тээврийн хэрэгслээс агаарт тоос тоосонцор үүсгэхгүй, олон салаа зам гаргахгүй байх, хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор улсын чанартай авто замыг 29 тэрбум төгрөгөөр барьж байгуулсан. Үйлдвэрийн авто зам барих үеийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх зарчмыг баримталж, сөрөг нөлөөллийг бууруулж ажилласан. 2019 онд үйлдвэрийн хүнд даацын авто замын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр Батлан хамгаалах яам ажиллаж Дорноговь аймгийн Сайншанд сумаас үйлдвэрийн талбай хүртэлх 17.5 км хүнд даацын автозамын ажлыг бүрэн дуусгаж 2019 оны 11 дүгээр сард Улсын комисст хүлээлгэн өгсөн.

Зураг 5: Үйлдвэрийн хүнд даацын авто зам





1.3.3 Төмөр зам

Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай нь Сайншанд хотоос 27 км төмөр замаар холбогдох бөгөөд салбар төмөр зам барих ажлын ерөнхий гүйцэтгэгчээр

“Улаанбаатар төмөр зам” ХХН ажиллаж 3,7 км холбоос зам, төмөр бетон гүүр, туннел зэргийг 2019 оны 10 дугаар сарын 08-нд Улсын комисст хүлээлгэн өгсөн.


Зураг 6: Үйлдвэрийн төмөр зам




1.3.4 Үйлдвэрийн усны эх үүсвэр, ус хангамжийн шугам хоолойн барилга, байгууламжийн ажил

Газрын тос боловсруулах үйлдвэрийн усны эх үүсвэр, ус хангамжийн шугам хоолойн байгууламжид нийт 11 гүний худаг, 84.579 км шугам хоолой, өргөлтийн насос станцын өмнө байрлах 100 м^3 эзлэхүүнтэй ус цуглуулах усан сан, өргөлтийн насос станц, үйлдвэрийн 3 хоногийн усны хэрэглээг нөөцлөх нийт 30,000 м^3 эзлэхүүнтэй, полиэтилен геомембран доторлогоотой, хөвдөг хучилттай 2 усан сан, эсрэг осмосын систем бүхий ус цэвэршүүлэх байгууламжууд байна. Үйлдвэрийн түүхий ус хадгалах, тус бүр 15,000 м^3 багтаамжтай 2 төмөр бетон савны барилгын ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Үйлдвэрийн усан хангамжийн хүрээнд Бор Хөөвөрийн говьд гүнийн усны 11 худаг, 40 км ус дамжуулах хоолой, өргөх насос станц, насос станцуудыг цахилгаанаар хангах нийт 86.57 км урт 10/35 кВ-ын ЦДАШ барихаар төлөвлөсөн бөгөөд барилгын ажлыг 2021.05.09-ний өдрөөс эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар дамжуулах хоолойн ажил бүрэн дуусаж, улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Зураг 7: Үйлдвэрийн ус хадгалах сав

1.3.5 Газрын тосны үйлдвэрийн хотхоны барилга, байгууламжийн ажил

Газрын тосны үйлдвэрийн хотхон нь 95 айлын 3, 40 айлын 5, 32 айлын 2 орон сууц, нийт 549 айлын орон сууц болон оффис-үйлчилгээний төвийн барилгаас бүрдэнэ. Хотхон барих төслийг 2 үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд I ээлжийн Ерөнхий гүйцэтгэгчээр “Хангай Бигэр” ХХК болон “Тобэм” ХХК, II ээлжийн Ерөнхий гүйцэтгэгчээр Батлан хамгаалах яамны 339-р анги тус тус ажиллаж байна. Зэвсэгт хүчний 339-р ангийн туслан гүйцэтгэгчээр “Баярс констракшн” ХХК, “Баян тосон” ХХК болон “Их даян бүүвэй” ХХК-ууд ажиллаж байна. Хотхоны I ээлжийн барилгуудыг 2024 онд ашиглалтад оруулж хүлээн авлаа.



Зураг 8: Газрын тосны үйлдвэрийн хотхоны ажлын явц

Зэвсэгт хүчний 339-р ангийн хариуцсан II ээлжийн орон сууцны барилга угсралтын ажил үргэлжилж байна. Гадна дулааны инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг “Одкон Холдинг” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд 2021.11.12-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад хүлээн авсан. Орон нутгийн дулааны эрчим хүчээр хангагч байгууллага болох "Чандмань Элч" ОНӨХХК-тай хэрэглэгчийн гэрээг байгуулан ажиллаж байна. Хотхоны цахилгаан хангамж, холбооны ажлын хүрээнд гадна цахилгааны шугам сүлжээ, хуваарилах байгууламж, дэд өртөө, холбооны шугам сүлжээ багтаж байгаа бөгөөд Ерөнхий гүйцэтгэгчээр "Майнс Ап" ХХК ажилласан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь дараах байдалтай байна. Үүнд:

- Дэд өртөөний барилга 100%
- Хуваарилах байгууламжийн барилга 100%
- Гадна цахилгааны кабелийн сувагчлал, сунгалт 100%
- Гадна холбооны кабелийн сувагчлал, сунгалт 100%

1.3.6 Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг 4 багц (EPC: Инженерчлэл-Худалдан авалт-Барилга угсралт) ажилд хуваан хэрэгжүүлж байна. Үүнд:

EPC-1: Технологийн бус барилга байгууламж

EPC-2: Анхдагч процессын болон дагалдах байгууламж

EPC-3: Үйлдвэрийн цахилгаан станц

EPC-4: Лицензтэй технологийн байгууламж

Үйлдвэрийн технологийн бус байгууламжийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг (EPC-1) гүйцэтгэхээр сонгон шалгарсан Энэтхэгийн “KPIL” компани

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хооронд 2020.10.02-ны өдөр гэрээ байгуулсан. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, төслийн менежментийн зөвлөх “Инженерс Индиа Лимитэд” компани болон “KPIL” компаниуд

2021.01.15-ны өдөр үйлдвэрийн талбайд технологийн бус барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, EPC-1 багц ажлын хүрээнд Иргэний барилга байгууламжууд, Үйлдвэрийн усан хангамж, Үйлдвэрийн талбайн дэд бүтэцийн ажлууд дуусаж улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

2023 оны байдлаар EPC-2, EPC-3, EPC-4 багц ажлын хүрээнд дараах 3-н багц ажлыг эхлүүлээд байна. Үүнд:


- EPC-2: Анхдагч процессын болон дагалдах байгууламж
- EPC-3: Үйлдвэрийн цахилгаан станц
- EPC-4: Лицензтэй технологийн байгууламж


Иргэний барилга байгууламж - Үйлдвэрийн иргэний барилга байгууламжуудын барилга угсралтын ажил хянагдсан зураг төслийн дагуу 100%-ийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Төслийн менежментийн зөвлөх компанийн болон манай компанийн инженерүүд үйлдвэрийн талбайд байрлаж, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Зураг 9: Газрын тосны үйлдвэрийн хотхоны ажлын явц









1.3.7 Төслийн байгаль орчны холбогдолтой тайлан, материалууд

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоох зорилгоор холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд дараах тайлан, материалуудыг боловсруулж батлуулаад байна. Үүнд:

- 2017 он – “Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих” МГТБҮ-17/01 дугаар бүхий зөвлөх үйлчилгээний “байгаль орчны төлөв байдлын суурь судалгааны тайлан”. Монгол, Англи – Эхопланет ХХК
- 2018 он Газрын тос боловсруулах үйлдвэрийн шинээр баригдах салбар төмөр зам Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан “Байгаль экологи”- ХХК
- 2018 он Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийг сайншанд хоттой холбох авто зам төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан “Цавчирын хөндий” ХХК
- 2020 он Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ “ Хатандалай” ХХК
- 2020 он Газрын тос боловсруулах үйлдвэрийн Ус хангамжийн систем Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан “Газар дэлхий” ХХК
- 2020 он – “Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрт газрын тос дамжуулах хоолой барих төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” – Найчрал састайнэблэ ХХК
- 2020 он – “Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрт газрын тос дамжуулах хоолой барих төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангийн хавсралтууд” – Найчрал састайнэблэ ХХК

- 2020 он – “Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулагдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай, Сайншанд дахь газрын тосны үйлдвэрийн хотхонд хамрах нутаг дэвсгэрт хэрэгжүүлсэн орчны хяналт-шинжилгээний ажлын тайлан”
- 2020.08 сар – “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай, хүнд даацын авто болон төмөр зам, үйлдвэрийн хотхонд хамрах нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн палеонтологийн нөөц баялгийн үнэлгээний тайлан – ШУА, Палеонтологийн хүрээлэн
- 2020.07 сар – “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай, хүнд даацын авто болон төмөр зам, үйлдвэрийн хотхонд хамрах нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн археологийн урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлт – ШУА, Археологийн хүрээлэн
- 2020.07 сар – “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай, хүнд даацын авто болон төмөр зам, үйлдвэрийн хотхонд хамрах нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн угсаатны зүйн судалгааны ажлын дүгнэлт – ШУА, Археологийн хүрээлэн
- 2020.10 сар – “Газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн шугам, хоолойн барилга, байгууламжид хамрагдах талбайд гүйцэтгэсэн палеонтологийн нөөц баялгийн үнэлгээний тайлан - ШУА, Палеонтологийн хүрээлэн
- 2020.10 сар – “Газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн шугам, хоолойн барилга, байгууламжид хамрагдах талбайд гүйцэтгэсэн угсаатан зүй судалгааны ажлын дүгнэлт” – ШУА, Түүх, угсаатны зүйн хүрээлэн
- 2020.10 сар – “Газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн шугам, хоолойн барилга, байгууламжид хамрагдах талбайд гүйцэтгэсэн археологийн урьдчилсан хайгуул, судалгааны ажлын дүгнэлт” – ШУА, Археологийн хүрээлэн
- 2020 он – “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”
- 2021 он – “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”
- 2021 он – “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”
- 2022 он – “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”
- 2024 он – “Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрт газрын тос дамжуулах хоолой барих төслийн байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан” – Найчрал састайнэблэ ХХК
- 2026 он Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Байгаль орчны төлөв байдлын тайлан “Их зос” ХХК
- 2026 он Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан “Их зос” ХХК
- 2026 он 35МВт Шингэн түлшээр ажиллах Дулаан цахилгаан станц барих төслийн Байгаль орчны төлөв байдлын тайлан “Төгрөг Баян Хангай” ХХК
- 2026 он 35МВт Шингэн түлшээр ажиллах Дулаан цахилгаан станц барих төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан “Төгрөг Баян Хангай” ХХК
- 2026 он Давст XXXI газрын тосны хайгуулын талбайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан “Эконатур” ХХК


2 ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД, АЛТАНШИРЭЭ СУМДЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4 дэх хэсэгт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах асуудлыг зохицуулсан байдаг ба тодруулбал, 8.4.1-р зүйлд төсөл хэрэгжих орчны өнөөгийн төлөв байдал, 8.4.2-р зүйлд Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн, 8.4.3-р зүйлд Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж 8.4.7-р зүйлд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд зэрэг асуудлыг тусгахаар зохицуулсан байдаг. Иймд, тус байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж улмаар төслийн баталгаажсан техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн мэдээлэлд тулгуурлаж төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцооллын үр дүн, төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан болно.


Физик газарзүйн нөхцөл

Монгол орны физик газарзүйн мужлалаар[2] “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн Монголын Дорнод талын их мужид хамаарах ба Дорнодын тэгш талын дэд мужийн Тамсагийн талын тойрогт багтаж байна.




ЗУРАГ

Байгалийн бүс бүслүүрийн ангиллаар[3] “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн хээрийн бүсэд багтаж байна



ЗУРАГ



ЗУРАГ

Зураг -т “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн дижитал өндөршлийн загвар (DEM)-д суурилсан рельефийн дүрслэлийг ашигласан болно. Өндөршил нь 557–1044 м хооронд хэлбэлзэж, баруун болон зүүн зах хэсэгт харьцангуй өндөрлөг бүсүүд, төв хэсэгт нам дор, тэгш гадаргуутай талбай давамгайлж байна. Зурагт татсан ягаан шугамаар өндрийн профайлыг доод хэсэгт график хэлбэрээр үзүүлсэн бөгөөд тухайн чиглэлд гадаргын налуу, өндөршлийн өөрчлөлт жигд бус байгааг илэрхийлж байна. Энэхүү өндөршлийн тархалт нь талбайн геоморфологи, гадаргын усны урсац, хөрс-элэгдлийн процесс болон хайгуул-ашиглалтын инженерийн шийдэлд чухал суурь мэдээлэл болно.

Геоморфологи


“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн геоморфологийн мужлалын хувьд Монголын Дорнод мужид хамаарч байна.

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн хэмжээнд идэгдэл-тектоникийн, элэгдэл-тектоникийн, хуримтлалын гэсэн 3 гадаргуу ялгагддаг.


- **Идэгдэл-тектоникийн:** 1’800-2’800 м үнэмлэхүй өндөртэй, гүн хэрчигдэлтэй дунд өндөртэй уулс, 1’500-1’800 м үнэмлэхүй өндөртэй, дунд зэргийн хэрчигдэлтэй нам уулс, 1’000-1’500 м үнэмлэхүй өндөртэй, хэрчигдэл багатай толгодорхог гадаргуутай, нам өндөртэй уулсаас тогтоно.
- **Элэгдэл-тектоникийн:** Мезозойн өмнөх үндсэн чулуулгаар хөгжсөн мөлгөр, хавтгай оройтой, эгц, босоо налуувтар хажуу бүхий дунд болон бага зэргийн хэрчигдэлтэй нам өндөртэй уулс, Мезозойн хурдсаар дүүргэгдсэн ухаа, гүвээт, жижиг толгодлог тэгш тал, Кайнозойн хурдсаар дүүргэгдсэн давхраат тэгш талын хэвшинжит гадаргуугаас тогтоно.
- **Хуримтлалын:** Хуримтлалын гадаргууг нь аллюви, аллюви-пролюви, пролюви нуурын хурдсаар дүүргэгдсэн хөндий, сайр, сайр гуу жалга ихтэй бага зэрэг долгиолог налуу, хажуу, хотгор, нуур, нуур-пролювийн хурдсаар дүүргэгдсэн хотгор зэрэг төрөл бүрийн гарал үүсэлтэй хурдас, хуримтлал бүрдүүлнэ.

Ландшафт

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн ландшафтын их мужаар Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж, Монголын Дорнод хэсгийн давхаргат болон суурьт өндөрлөг тал, тэгшдүү хотгор, сул сэргэж хэлбэржсэн үлдмэл-цулдам уулын муж, Тамсагийн давхаргат өндөрлөг тал, тэгшдүү хотгор бүхий хуурай хээрийн дэд муж, хээр гэсэн бүсэд орж байна



ЗУРАГ 2-1 ЛАНДШАФТЫН ЗУРАГ




ЗУРАГ 2-2 ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЗҮГ ЗОВХИС

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн хэмжээнд рельефийн зүг зовхисыг (aspect) сансрын зураг болон дижитал өндрийн загвар (DEM)-д тулгуурлан тодорхойлж, ангилсан болно (Зураг 2-2-г харна уу). Зургийн өнгөний ялгарал нь налуу гадаргын аль зүг рүү хандсан байршлыг илэрхийлэх бөгөөд хойд, зүүн хойд, зүүн, зүүн урд, урд, баруун урд, баруун, баруун хойд чиглэлүүдийг градусын интервалд ангилан харуулсан.

Судалгааны талбайд бүх чиглэлийн зүг зовхис тархсан бөгөөд уул, толгодын бүсэд зүг зовхисын өөрчлөлт ихтэй, нарийн шигүү тархалт ажиглагдаж байна. Харин тэгш гадаргуу бүхий хэсгүүдэд зүг зовхис жигд буюу тодорхой бус (тэгш) байдал давамгайлж байна.

Зүг зовхисын мэдээлэл нь тухайн талбайн бичил уур амьсгал, хөрсний чийг, ургамлын тархалт, мөн инженер-геологийн нөхцөлийг үнэлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд цаашдын хайгуул, ашиглалтын үе шатанд байгаль орчны нөлөөллийг үнэлэх, төлөвлөлт хийхэд ашиглагдана.




ЗУРАГ 2-3 ТӨСЛИЙН ТАЛБАЙН НАЛУУЖИЛТ

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн гадаргын налуугийн тархалт. Зураг 2-3-д үзүүлснээр талбайн зонхилох хэсэг 0-6°-ийн налуутай тэгш хээрийн гадаргатай бөгөөд 6–10°-ийн бага налуу нь голын хөндий болон зарим задгай гадаргад тархсан байна. Харин 10°-оос их налуутай хэсгүүд хязгаарлагдмал тархалттай байгаа нь бүс нутгийн рельефийн жигд, тэгш шинжийг илтгэнэ.

Геологи

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайд протерозойн, палеозойн (дунд, дээд), мезозойн (доод, дээд) болон кайнозойн эрин үеийн хурдсууд тархсан байна (Зураг 2-4 харна уу).



ЗУРАГ 2-4 ТӨСЛИЙН ТАЛБАЙН ГЕОЛОГИЙН ЗУРАГ

Кайнозой /KZ/ эрин:

- Нуурын гаралтай lQ2 - шавар, шавранцар
- Аллюви- пролювийн гаралтай apQ2 – шавар, элсэнцэр, элс, хайрга, сайрга
- Делюви-пролювийн гаралтай dpQ1-2 – элс, шавар элсэнцэр, шавранцар, хэмхдэс
- Пролюви pQ2 - чулуулгийн үйрмэг хэмхдэс бүхий элс, элсэнцэр

Доод неогены N1HN Хөх нуур формац. Т.Биндэръяа нар /1996/ анх Хөх нуурын нэрээр нэрлэж ангилсан бөгөөд энэ нь Хөх нуур, Эрээнцав, Жирмийн нуур, Харт, Шарбүрд зэрэг газарт тархжээ. Мөн Нүхт давааны серийн Нүхт давааны бүс, Баруун-Уртын дэд бүсүүдэд шорвогийн нуур зэрэг газарт тэгш тал үүсгэдэг ба заримдаа уулын араар налуу хажуутай ухаа үүсгэдэг. Хормой голын, гол нуурын гаралтай бор шаргал өнгөтэй, хэвтээ байрлалтай хурдсыг төстэй шинжээр нь Хөх нуур формацид анх Ш.Лхүндэв 1998 онд ангилжээ. Өмнөх судлаачид энэ хурдсын зарим хэсгийг голын гаралтай эртний дөрөвдөгчийн хурдсанд, үлдсэнийг гуравдагч галавт оруулсан байдаг (С.Д.Иванов, 1954). Голын гол-нуурын гаралтай шаргал цайвар, шаргал өнгөтэй элс, хайрга, сайрга хааяа ногоовтор шаргал шавар шавранцарын үе илэрдэг байна.

Мезозой /MZ/ эрин:

Дээд цэрдийн K2bs Баянширээ формац. Анх Дорноговь аймгийн Баянширээ уулын дүүрэгт И.Е.Турищев ялгаж, дээд цэрдийн сеноман-сантон яруст хамааруулжээ. Энэ формацын хурдас нь говь, талын бараг бүх нутагт өргөн тархацтай байх бөгөөд палеозой, түрүү мезозойн хурдсыг эрс үл нийцлэгээр хучиж, дээд цэрдийн Баянзаг, Баруунгоёотын формацуудаар тасалдалтайгаар хучигддаг. Уг формац нь 60-70 м зузаантай, динозавр, зөөлөн биетэн, остракод зэрэг амьтдынбаялаг олдвор агуулсан хөх өнгийн шавар, элс,

элсэнцэр, хайрганцар, алевролит, гравелит, цагаан-саарал өнгийн элсжин, конгломерат, улаан өнгийн элсэрхэг шаврын зузаалгаас тогтоно.

Палеозой /PZ/ эрин:

Доод цэрдийн k1cc Цагаанцав формац. Региональ стратиграфийн Цагаанцав горизонтыг төлөөлдөг. Энэ формацыг анх 1954, 1956 онуудад И.Е.Туришев Дорноговь аймгийн Цагаанцав худгийн нэрээр ялгаж, насыг нь доод цэрдэд хамааруулсан байдаг. Тулгуур зүсэлтийг нь мөн аймгийн Харангад уулын зүүн бэлд хийжээ. Энэ формацын хурдас нь Өмнөговь, Дундговь, Дорноговь, Дорнод аймгуудын нутагт өргөн тархсан байх ба фаун бүхий вулканоген-тунамал зузаалгаас тогтоно. Түүний зүсэлтийн доод талд нь конгломерат, гравелит үелсэн агломерат, туф, базальт, андезит-базальт, трахибазальт, трахиандезитуудаас, харин дээд талд нь конгломерат, элсжин, шохойжин, шавар, туф элсжин, туф-атевролитоос тогтоно. Нийт зузаан нь 250-1100 м.

Матад бүрдэл y2C2m. Чулуулгууд нь габбро, габбродиорит, диорит, гранодиорит, боржингоос бүрдэнэ.

Уур амьсгал

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн бичил цаг уурын нөхцөлийг тодорхойлох зорилгоор Матад болон Халхгол сумдын цаг уурын станцуудын 2016-2025 оны цаг уурын үзүүлэлтүүдийг Цаг уур орчны шинжилгээний төвөөс авч энэхүү үнэлгээний тайланд ашиглав. Станцуудын байршлыг Зураг 2-5-т харуулав.




ЗУРАГ 2-5 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙТАЙ ОЙР ОРШИХ ЦАГ УУРЫН СТАНЦУУДЫН БАЙРШИЛ

Агаарын температур

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай орчмын сүүлийн 10 жилийн (2016-2025) дунджаар агаарын температур 1.7 ˚C байна. 2016-2025 оны хооронд агаарын температурын дундаж хэлбэлзлээс үзвэл 2024 онд температурын дундаж утга хамгийн их (4.7) байна. Энэ нь Монгол орны дундаж (1.8[4])-аас 2.6 дахин их байна. 2025 онд жилийн дундаж температур

[4] https://www.extremeweatherwatch.com/countries/mongolia/average-temperature-by-year?utm_source

Матад станцын орчим 2.9˚С, Халхгол станцын орчимд 1.1˚С байна. Төслийн талбай орчимд байрлах дээрх 2 станцуудын байршлуудыг харьцуулахад Матад станцын орчмоор агаарын температурын дундаж утга хамгийн их байгаа нь Зураг 2-6-аас харагдаж байна.




Зураг 2-6 жилийн дундаж агаарын температурын хэлбэлзэл , 2016-2025 он

Хүснэгт 2-1 төслийн сумдын агаарын температур, сараар, 2015-2024 оны дунджаар

Станц	*I*	*II*	*III*	*IV*	*V*	*VI*	*VII*	*VIII*	*IX*	*X*	*XI*	*XII*
Матад станц	-18.06	-15.15	-4.3	4.64	12.25	18.9	22.16	18.51	12.9	2.4	-8.76	-16.7
Халхгол станц	-23.34	-19.24	-7.1	3.6	11.3	17.87	21.46	18.2	14.2	1.5	-10.4	-17.2

Хүснэгт 2-1-д олон жилийн дундаж агаарын температурын сарын хэлбэлзлийг үзүүлэв.


Зураг 2-7-д үзүүлснээр 2016 оны байдлаар Төслийн талбай орчмын агаарын температурын дундаж зуны улиралд 20.7˚С бол 2025 онд 19.9˚С болж өөрчлөгдсөн байна. 2025 онд өвлийн улиралд -18.2˚С, хаврын улиралд 3.9˚С, зуны улиралд 19.9˚С, намрын улиралд 2.5˚С байна[5].



Зураг 2-7 агаарын дундаж температурын улирлын хэлбэлзэл, станцуудын дундаж утгаар


Хур тунадас

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай орчмын хур тунадасны нийлбэрийг 2016-2025 онуудад дараах станцуудын хэмжилтээс үзэхэд 2018, 2021, 2024 онуудад Халхгол станцад хамгийн их хур тунадас орсон буюу 480-540 мм хүртэл байна. Харин Матад станцын орчимд хур тунадасны нийлбэр Халхгол станцын орчмоос арай бага унадаг нь харагдаж байна. 2015 оны байдлаар 93.2 мм байгаа бол сүүлийн жилүүдэд аажмаар өссөөр 2024 онд 319 мм хур тунадас орсон байна. Энэ нь гэхдээ зөвхөн Халхгол станцад бус бусад 2 станцад ч өндөр байгаа нь 2024 онд тус бүс нутгаар хур тунадас ахиу орсныг харуулж байна. Үүнийг дэлгэрүүлж үзвэл 2024 оны 8-9-сар саруудад тухайн Төслийн ойролцоох нутгаар их хэмжээний хур тунадас орсон байна[6]. Зураг 2-8-аас харагдаж байна.




Зураг 2-8 жилийн хур тунадасны нийлбэр, 2016-2025 он

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай орчмын хур тунадасны нийлбэрийг сараар нь авч үзвэл зуны 7, 8, 9-р саруудад хамгийн их буюу 50-100 мм хүртэл тунадас ордог байна. Өвлийн 1, 2-р саруудад хамгийн бага 1-4 мм хур тунадас ордог нь Зураг 2-9-оос харагдаж байна. Харин Халхгол станцад бүртгэгдсэн мэдээгээр 7-р сард тус хэмжилтийн онуудад хамгийн их буюу 106 мм хур тунадас орсон байна.



Зураг 2-9 тухайн сард ордог дундаж хур тунадасны хэмжээ, 2016-2025 он


Төсөл хэрэгжиж буй талбай орчимд зуны улиралд хур тунадасны нийлбэр 2016-2025 онуудад дунджаар 187 мм ордог байна. Сүүлийн жилүүдэд жилд ордог хур тунадасны хэмжээ харилцан адилгүй, хэлбэлзэлтэй байна. Харин өвлийн улиралд 2016-2025 онуудад 12 мм орчим орж байна. Харин намрын улиралд эдгээр онуудад 22 мм ордог байсан бол сүүлийн 10 жилд 2020 болон 2021 онуудад хур тунадасны нийлбэр хамгийн өндөр байна[7]. Төсөл хэрэгжих бүс орчмын хур тунадасны улирлын хэлбэлзлийг Зураг 2-10-т үзүүлэв.



Зураг 2-10 хур тунадасны улирлын нийлбэр, станцуудын дундаж

Агаарын харьцангуй чийгшил


Давст-XXXI талбай орчмын агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ 2016-2025 оны хооронд дунджаар 57.9% байна. Төслийн талбай орчмын агаарын чийгшлийн хэмжилтээр бүх станцуудад харьцангуй чийгшил буурч, 2025 онд хамгийн бага түвшинд хүрсэн байна. 2020, 2021 онуудын агаарын чийгшил сүүлийн 10 жилд хамгийн өндөр байна. Энэ нь мөн онуудад хур тунадасны хэмжээ хамгийн их байсантай нийцэж байна. 2025 онд Төслийн талбайн Матад станц орчимд чийгшил буурч, хуурайшил нэмэгдсэн үзүүлэлттэй. 2021 оноос хойш Халхгол орчимд мөн чийгшлийн хэмжээ буурсан хандлага ажиглагдаж байна.



Зураг 2-11 агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ, жилийн дунджаар, 2016-2025 он


[7] Ус цаг уур, орчны шинжилгээний газар

2016-2025 оны хооронд олон жилийн дундаж харьцангуй чийгшлийн хэмжээ нь 2 станцуудад ойролцоо үзүүлэлттэй байгаа ба 4-5-р сард хамгийн бага хэмжээтэй буюу 35-49%-ийн хооронд хэлбэлзэж байна (Зураг 2-12-харна уу). Харьцангуй чийгшил нь нэгдүгээр (I) болон арван хоёрдугаар (XII) саруудад хамгийн өндөр, харин дөрөвдүгээр (IV) сараас зургадугаар (VI) сар хүртэл хамгийн бага байна. Энэ нь Монгол орны хуурайшилт ихтэй дулааны улирал (IV–VI сар) болон чийглэг хүйтэн улирал (I, XII сар)-тай уялдаж байна.



Зураг 2-12 агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ, сарын өөрчлөлт, 2016-2025 оны дунджаар


Зураг 2-13-д харуулснаар Газрын тосны хайгуулын Давст-XXXI талбай орчмын хэмжилтийн станцуудын дундаж утгаас үзэхэд агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ олон жилийн дунджаар зуны улиралд 60.7%, намрын улиралд 61.4%, өвлийн улиралд 63.2%, хаврын улиралд 46.3% орчим байна. Хаврын улиралд чийгшлийн хэмжээ хамгийн бага байгаа нь манай оронд өвөл бага хур тунадас орж (2021 онд өвлийн улиралд хамгийн бага), орсон цас нь хаврын 3 дугаар сараас эхэлж хайлаад хаврын улиралд салхи ихтэй байдагтай холбоотой хэмээн үзэж байна.



Зураг 2-13 агаарын харьцангуй чийгшлийн улирлын хэлбэлзэл, станцуудын дунджаар, 2016-2025 он


2.1.1.1 *Салхины хурд*

Зураг 2-14-д үзүүлснээр “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай орчмын салхины олон жилийн дундаж (2016-2025 он) хурд Матад станцад 4.9-5.6 м/сек, Халхгол станцад 2.9-4.6м/сек-ийн хооронд байна. Халхгол станцын орчимд салхины хурд 2016-2020 оны хооронд Матад станцтай харьцуулахад бага зэргийн их (2.9-3.3) байна.



Зураг 2-14 салхины дундаж хурд, м/с

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай орчмын салхины хурд улирлын хэлбэлзлийг Зураг 2-15-д үзүүлэв. Салхины хурд хаврын улиралд хамгийн их, намар, зуны улиралд хамгийн бага байдаг нь ажиглагдаж байна. Ерөнхий улирлын хэлбэлзлийг үзүүлсэн графикаас харахад сүүлийн жилүүдэд салхины хурд аль ч улиралд нэмэгдсэн бага багаар нэмэгдсээр байна[8]. Хаврын улиралд салхины хурд дунджаар 5.1 м/с, өвөл болон намрын улиралд дунджаар 4.5м/с, зун 4м/с байна.



Зураг 2-15 салхины хурд, улирлаар, 2016-2025 он

[8] Уур амьсгалын мэдээллийн сан. https://eic.mn/climate


Уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас уур амьсгалд үзүүлэх нөлөөллийг төслөөс уур амьсгалд үзүүлэх нөлөөлөл буюу хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлтөөс төсөлд учрах эрсдэл гэсэн хоёр чиглэлээр авч үзэв. Хүлэмжийн хийн ялгарал нь орон нутгийн агаарын чанарын бохирдуулагчаас ялгаатай бөгөөд орон зайн хувьд хязгаарлагдахгүй, дэлхийн уур амьсгалын системд хуримтлагдан нөлөөлдөг онцлогтой тул тусад нь үнэлэв.

2.4 Хөрсөн бүрхэвч

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн хөрсний хэв шинжийн тархалтыг (М1:100,000) Зураг 2-16-т үзүүлэв. Хөрсний дээж авах байршлуудыг нийт 15,528 км2 бүхий төсөл хэрэгжих бүс нутгийн хөрсний онцлогийг төлөөлөхүйц байдлаар нарийвчлан сонгосон. “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн бүс нутгийн нийт хөрсний дээжийг 2025.12.23-25-ны хооронд 17 цэгээс (Зураг 2-16-г харна уу) авч 17 дээжийн шинж чанарыг тодорхойлохоор лабораторийн шинжилгээнд илгээсэн (**Error! Reference source not found.**-г харна уу, бусад бүх хөрсний тайлбарыг Хавсралт С-с үзнэ үү).

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн бүс нутаг нь ердийн хүрэн, мараалаг хүрэн, нугат хүрэн, элсэн хүрэн, карбонатлаг хүрэн, дутуу хөгжилтэй хүрэн, үлдмэл нугархаг хүрэн, уулын нимгэн хар хүрэн, сайргархаг нимгэн хар хүрэн, карбонатгүй хар хүрэн, ердийн хар хүрэн, Хужир мараат хам бүхий зонхилох хөрсний хэв шинж тархсан байна



ЗУРАГ 2-16 СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ЗОНХИЛОХ ХӨРСНИЙ ХЭВ ШИНЖИЙН ТАРХАЛТ

Хүрэн шороон хөрс: Нам өндөртэй цав толгодын бэл, тэдгээрийн хоорондох уудам хөндий болон Хэрлэн голын хөндий, дэнж, татам орчимд илэрнэ. Тус хэв шинжийн хөрсний ургамал бүрхэвч нь үетэнт, агь-үетэнт, алаг өвс- үетэнт хуурай хээрийн ургамал зонхилно. Хуурай хээрийн бүсэд орших учир чийгийн хангамж дутагдалтай, хөлдөлт бага гүнд явагддаг, зуны хур бороонд хөрсний өнгөн 20-30 см гүн хэсэг норж чийглэгддэг тул карбонат хуримтлалын давхарга нягтарч хатуурсан байдаг.

Ялзмаг хуримтлалын А давхарга нь бараандуу болон хүрэн өнгөтэй, бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй, жижиг үйрмэг хайрга сайр чулуутай, шилжилт нь өнгөөр тод ялгарч харагддаг. Энэ давхаргын дор карбонат хуримтлалын В (ВС, С) давхарга шууд илрэх тохиолдол байдаг. Шилжилтийн В давхарга нь цайвар бор өнгөтэй, нягтавтар, зузаавтар, эртний цэвдэг болон мараалаг шинж тод илрэлээ олсон байдаг. Карбонат хуримтлалын ВС,

С давхарга нь тод бор, цайвар өнгөтэй, нягтарч хатуурсан байдаг. Карбонатын нэвчмэл цагаан толбо хөрсний үе давхаргад тод илэрдэг.

Төсөл хэрэгжиж буй талбайд гадаргын хэв шинж болон ландшафтын онцлогоос шалтгаалан хүрэн шороон хөрсний дэд хэв шинж болох жинхэнэ хүрэн хөрс, хүрэн шороон хөрсний төрөл зүйлүүд өргөн тохиолдоно.

Үлдмэл мараалаг цайвар хүрэн хөрс: Судалгааны талбайд түр зуурын ус тогтдог, нэмэлт чийгээр хангагдах боломжтой, хотос нам дор газруудаар тархсан. Чийгсэг, давссаг ургамал ихтэй, ургамлын Морфологи шинжийн хувьд хөрсний өнгөн 10-20 см-ийн үржил шимт үе давхарга нь сулавтар хөгжиж, бүдэг илэрсэн , 20-30 см-ийн гүнд нягтарч хатуурсан призм хэлбэрийн бүтэцтэй, мараалаг давхарга үүссэн. Судалгааны талбайд тархсан мараалаг хэлбэрийн хөрс нь сайрын гүйцэт тогтворжоогүй элсэн хөрстэй хил залган, хуурай жалга сайрын эмжиж тогтсон бөгөөд түүний мараалаг шинж нь үлдмэл байдалтай, гарал үүслийн хувьд жижиг булаг болон горхины нөлөөгөөр тогтворжсон чийгт гарлын хөрс хатаж хуурайших явцад түүний хөрсөн бүрхэвч хувирч өөрчлөгдөн үлдмэл нугархаг шинжтэй болсон байна. Ургамал бүрхэц нь 60-80% хүрэх ба голчлох ургамлын зүйл нь дэрс, чийгсэг ургамал голлох боловч ургамлын үндэсний тархалт бага гүнтэй байна. Мараалаг хөрсний морфологи бүтцийн зүсэлтийг дэрс бүхий элсэн хучаастай газар хийсэн.

Хөрсний урвалын орчин (pH): Энэхүү үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс шалтгаалж тухайн хөрсөнд явагдах химийн урвал нь шууд болон урвуу хамааралтай байдаг. “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн хөрсний pH 8.18-9.06 хооронд хэлбэлзэж байна. Геоморфологийн бүтцээрээ саармаг, бага зэрэг шүлтлэг болон дунд зэргийн шүлтлэг ангилалд хамаарна (**Error! Reference source not found.**-г үзнэ үү).

Хөрсний цахилгаан дамжуулах чанар (EC dS/m): EC буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт бөгөөд 0.0-0.75dS/m давсгүй, 0.75-2.0dS/m бага зэрэг, 2.0-4.0dS/m дунд зэрэг, 4.0-8.0 dS/m их, 8.0-15.0dS/m маш их гэж ангилдаг[9]. 0-20 см-ийн гүнд хэмжсэн хөрсний давхаргаас харахад хялбар уусах давсны агууламж “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн 0.061-0.344 dS/m хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд давсгүй ангилалд багтана[10] (**Error! Reference source not found.**-г үзнэ үү).

Хөрсний карбонат ($CaCO_3$): Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO_3) нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсний карбонатыг хөрсний давхаргын агууламжаар нь 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж ангилдаг[11]. Төслийн талбайн хөрсний карбонатын агууламж 0-4.75% хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд дээр дурдсан хөрсний карбонатын ангиллын дагуу хөрсний карбонатын агууламж нь сул карбонатжсан болон дунд зэрэг карбонатжсан ангилалд багтаж байна (**Error! Reference source not found.**-г үзнэ үү).

Хөрсний ялзмаг (SOM): Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй эрдэс, органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Төслийн талбайн хөрсний төрөл, орон нутгийн ус-цаг уурын нөхцөл, байгалийн тогтоцтой холбоотойгоор

ялзмагийн хэмжээ өөрчлөгддөг. Ялзмагийн агууламжийг >1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд, 5%< их гэж ангилна. Төслийн талбайн хөрсний ялзмагийн агууламж 1.06–4.97% хооронд хэлбэлзэж байна. Ангиллын дагуу хөрсний ялзмагийн агууламж бага, дунд ангилалд багтаж байна (**Error! Reference source not found.** үзнэ үү).

Хөрсний шим тэжээлийн элементийн нийлбэр ($K_2O+P_2O_5$): Ургамлын ургалт, хөгжилд зайлшгүй шаардлагатай азот, фосфор, кали зэрэг макро элементүүд нь байгалийн болон ургамлын задралын процессоос хөрсний давхаргад хуримтлагддаг. Эдгээрээс калийн исэл (K_2O) болон фосфорын пентоксид (P_2O_5) нь ургамлын өсөлтөд зайлшгүй шаардлагатай макро элементүүд бөгөөд энергийн дамжуулалт, фотосинтез, бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрдүүлэх зэрэг үйл явцад оролцдог. Калийн ислийн агууламжийг <10мг/100гр маш бага, 11-20мг/100гр бага, 21-30мг/100гр дундаж, 31-40мг/100гр дунджаас дээгүүр, 41-50мг/100гр их, >50 мг/100гр маш их гэж үздэг бол фосфорын агууламжийг <1 мг/100гр маш бага, 1-1.5 мг/100гр бага, 1.5-3.0 мг/100гр дундаж, 3.0-4.5 мг/100гр дунджаас дээгүүр гэж ангилна. Төслийн талбайн хөрсний хөдөлгөөнт фосфор (P_2O_5) 0.1-7.1 мг/100 гр**,** кали (K_2O) 13-87 мг/100 гр хооронд хэлбэлзэж байна (**Error! Reference source not found.**-г үзнэ үү).

2.5 Гадаргын ус


Монгол орон нь 29 голын сав газарт хуваагддаг ба “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай нь Буйр нуур-Халхгол, Мэнэнгийн тал болон Хэрлэн голын сав газарт[12] хамаарагдаж байна.

Буйр нуур–Халх голын сав газар нь Монгол Улсын зүүн захад байрлах, гадаргын усны нөөц харьцангуй сайн бүрдсэн сав газруудын нэг юм. Сав газрын голлох гадаргын усны эх үүсвэр нь Нөмрөгийн нуруунаас эх авч урсах Халх гол, Азаргын гол болон Буйр нуур, Хунт нуур зэрэг байгалийн нууруудаас бүрдэнэ. Халх гол нь байнгын урсацтай, сав газрын усны горимыг тодорхойлогч гол усан сүлжээ бөгөөд сав газрын гадаргын ус нь экологийн болон хил дамнасан ач холбогдолтойд тооцогддог[13].

Мэнэнгийн талын сав газар нь Монгол Улсын зүүн хэсгийн тал хээрийн бүсэд байрлах бөгөөд гадаргын усны нөөц харьцангуй хязгаарлагдмалд тооцогдоно. Сав газрын гадаргын ус нь голчлон Баян нуур, Төгөлдөр тойром, Сүжиг нуур зэрэг байгалийн нуурууд, улирлын чанартай түр ус тогтоц, намгархаг хотгоруудаар илэрдэг. Байнгын урсацтай гол, горхи ховор бөгөөд гадаргын усны нөөц нь хур тунадас, цас хайлах үйл явцаас ихээхэн хамааралтай, улирлын чанартай хэлбэлзэл ихтэй онцлогтой[14].

Хэрлэн голын сав газар нь Монгол Улсын зүүн бүсийн хамгийн томоохон гадаргын усны нөөцтэй сав газруудын нэг бөгөөд Хэнтийн нуруунаас эх авч урсах Хэрлэн гол, түүний олон тооны цутгал гол, горхиос бүрдсэн өргөн усны сүлжээтэй. Гадаргын усны нөөц нь хур тунадас, цас хайлалтын нөлөөгөөр бүрэлдэж, улирлын чанартай хэлбэлзэлтэй боловч жилийн дундаж урсцын хэмжээ харьцангуй өндөр байдаг. Сав газрын гадаргын ус нь унд, ахуйн болон хөдөө аж ахуйн усан хангамж, экосистемийг тэтгэхэд стратегийн ач холбогдолтой[15].

түүнээс бага, зөвхөн зарим хэсэгт 100-150 мм, өвлийн улиралд 10 мм-ээс бага хур тунадас унана. Тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч нуур, тойром, худгийн усны түвшин өөрчлөгдөнө. Цас их унаж хайлах, үргэлжилсэн ширүүн бороотой үед хотос хонхор газар, нуурууд нь устай болох ба хуурай сайрууд нь гол болж ус урсах, бороо хур татрахад усгүй болно.



2.6 Газрын доорх ус

Мэнэнгийн талын сав газрын геоморфологи, гидрогеологи

Мэнэнгийн талын сав газар болон түүнтэй уялдан орших Баруун урт, Төгөлдөр тойром, Баян нуур, Сүжиг нуурын савууд нь Монгол орны зүүн урд хэсэгт, зүүн уртрагийн 113°43′–119°13′, хойд өргөргийн 45°23′–47°55′-ын хооронд байрлаж, нийт 53,371 км² талбайг эзлэн оршино. Сав газруудын хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1777 м өргөгдсөн Шилийн богд уул бөгөөд хамгийн нам цэг нь Мэнэнгийн талд орших 649 м-ээс доош суусан хотгор юм.

Савуудын геоморфологийн үндсэн хэв шинжийг 750–1200 м өндөртэй тэгш тал, дарагдмал хөндий, толгод, нам уулс тодорхойлж, 1300–1600 м өндөртэй уулс сав газрын зах хязгаарыг бүрдүүлнэ. Баруун хойд хэсгээр түрмэл чулуулгаас тогтсон Хөх өндөр, Шувуун толгойт уулс, баруун талаараа палеозойн тунамал чулуулгаас тогтсон Сүхбаатарын өндөрлөгийн зүүн төгсгөл, төв хэсгээр Баян тэрэг, Матад, Тахилгаатын уул нурууд, баруун өмнөд болон зүүн өмнөд хэсгээр Дарьгангийн өндөрлөг, Хөхдийн нуруу зэрэг уул нуруудтай уялдан оршино.

Уул нуруудын хооронд Мэнэн, Тамсаг, Жаран тогоо, Тал булаг, Буян овооны товч, Шороот цагаан нуур, Шаварт нуур, Цагаан даравгай, Өвөр, Хөх нүдэн нуур зэрэг баруун өмнөөс зүүн хойш сунаж тогтсон ус хурах хотгор, хөндий, талууд зонхилно.

Сүжиг нуурын сав нь мезозойн түрмэл, палеозойн тунамал, кайнозойн хурдсаас тогтсон бөгөөд доод цэрдийн намгархаг эх газрын тунамал, неоген, голоценийн хурдсаар өргөн тархсан байна. Шавар, элс, хайрга, хайргархаг хурдас зонхилж, ус агуулагч чанар харьцангуй сайн бүсүүдийг бүрдүүлдэг.

Мэнэнгийн талын сав газар болон түүнийг хүрээлэн орших савууд нь газарзүйн мужлалаар Монголын дорнод мужийн баруун хойд, Тамсаг–Мэнэнгийн, Баянзүрхийн, Дарьганга–Нүхт давааны дэд мужид хамрагдана (Д.Доржготов, 2009).

Эдгээр сав газруудын хэмжээнд газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц нь гол төлөв дөрөвдөгчийн настай аллювий, пролювийн гаралтай элс, хайрга, элсэнцэр, шавранцраас тогтсон нүх сүвэрхэг хурдсанд хуримтлагдсан байна. Монголын гидрогеологийн 1:1,000,000 масштабын зурагт тэмдэглэснээр дөрөвдөгчийн настай ус агуулагч бүрдэлд өрөмдсөн цооногуудын ус 0.7–1.6 м гүнд илэрч, усны түвшинг 8.4 м бууруулан шахахад 10–16 л/с ундарга өгч байжээ. Ихэнх цооногуудын ундарга 1.0 л/с орчим байна.

Неогенийн настай шаргалдуу хурдас, элсэнцэр, хайргат ус агуулагч давхаргад газрын доорх ус 4.2 м гүнд илэрч, түвшинг 6.6 м бууруулан шахахад 15 л/с ундарга өгсөн нь тухайн бүсийн хамгийн өндөр ундаргатай ус агуулагч бүрдэлд тооцогдоно. Харин доод болон дээд цэрдийн ус агуулагч бүрдлүүд нь ерөнхийдөө төстэй боловч дээд цэрдийн бүрдэл харьцангуй илүү ундаргатай байна.

Сав газрын нутаг дэвсгэр нь хуурай дулаавтар уур амьсгалын мужид багтах ба дундаж жилийн хур тунадас 276.6 мм орчим. Газрын доорх усны тэжээгдэлд конденсацийн нөлөө бага, харин агаарын хур тунадас голлох үүрэгтэй. Ялангуяа 6–8 дугаар саруудад хур тунадас төвлөрч, энэ үед газрын доорх усны түвшин улирлын шинжтэйгээр дээшилдэг зүй тогтол ажиглагдана[16].

2.1.1 Буйр нуур–Халх голын сав газрын газрын доорх усны геоморфологи, гидрогеологи

Буйр нуур–Халх голын сав газар дахь газрын доорх усны сав нь Монгол орны зүүн захын бүсэд байрлах бөгөөд Нөмрөгийн нуруунаас эх аван урсах Буйр нуур, Халх гол, Азаргын гол зэрэг гадаргын усны сүлжээтэй уялдан тогтсон байна. Тус сав газрын нутаг дэвсгэр нь уул нурууд, тэгш тал, дарагдмал хотгор, голын хөндий зэргээс бүрдэх бөгөөд газрын доорх ус хуримтлагдах нөхцөл геоморфологийн хувьд харьцангуй таатай бүсүүдийг агуулдаг.

Сав газрын баруун болон баруун өмнөд хэсгээр нам уулс, толгод зонхилж, төв болон зүүн хэсэгтээ тэгш тал, хөндий, элсэрхэг гадарга давамгайлна. Эдгээр хэлбэршил нь газрын доорх усны урсгал, хуримтлалын чиглэлд шууд нөлөөлж, ус агуулагч бүсүүдийг гол төлөв голын хөндий, аллюви болон пролювийн хурдсаар бүрхэгдсэн хэсгүүдэд төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Буйр нуур–Халх голын сав газар дахь газрын доорх ус нь гидрогеологийн хувьд Буйр нуурын хотгор, Халх голын хөндий, түүнчлэн тэдгээртэй уялдсан нам талын хотгор бүсүүдэд илүү гүнзгий хөгжсөн байна. Эдгээр хэсэгт газрын доорх усны тэжээгдэл нь гол төлөв атмосферийн хур тунадас, гадаргын усны шүүрэл, улирлын чанартай урсацтай холбоотой бөгөөд хуурай уур амьсгалын нөхцөлд улирлын хэлбэлзэлтэй илэрдэг.

Региональ гидрогеологийн хувьд Буйр нуур–Халх голын сав газрын газар доорх усны тогтолцоо нь Амар мөрний ай савтай уялдах транзит бүсэд хамрагдах бөгөөд улмаар Номхон далайн ай савд хамаарах ус хураах системийн нэг хэсэг болдог. Сав газрын хэмжээнд гол төлөв голоцен, плейстоцений настай аллюви, аллюви-пролювийн хурдсанд ус агуулагдаж, зарим хэсэгт неоген болон доод цэрдийн настай хурдсууд ус агуулах үүрэг гүйцэтгэнэ.

Мөн палеозойн болон мезозойн настай хатуу чулуулгийн бүсүүдэд ан цавлаг шинжтэй ус агуулагч орчин тархсан боловч эдгээр нь орон зайн хувьд тасалдсан, ус хуримтлуулах боломж хязгаарлагдмал шинжтэй байна. Иймээс сав газрын хэмжээнд газрын доорх усны ашиглалтын боломж нь ихэвчлэн сул сийрэг хурдсаар бүрхэгдсэн хөндий, нам талын хэсгүүдэд төвлөрдөг[17].

Гүний усны нөөц

Буйр нуур-Халх голын сав газар дахь газрын доорх усны нөхөн сэргээгддэг болон баримжаат нөөц[18]

Нөхөн сэргээгддэг нөөц: Буйр нуур–Халх голын сав газрын дэвсгэр нутагт Азарга гол болон Зүүн, Дунд, Баруун шаварт нууруудын сав газрууд багтдаг бөгөөд эдгээр бүсэд газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц тархсан байдлыг **Error! Reference source not**

found.-т үзүүлсэн болно. Уг зургийг боловсруулахдаа Монгол Улсын Усны мэргэжилтнүүдийн хамтран 1981 онд зохиосон “Монгол орны гадаргын болон газрын доорх усны олон жилийн дундаж урсцын зураг”-ийг иш үндэс болгосон.

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийг нэгж талбайд (мм/жил/км²) оногдох хэмжээгээр дараах дөрвөн ангилалд хуваан үнэлсэн. Үүнд:


1) Тун бага нөхөн сэргээгддэг нөөцтэй (0–5 мм/жил/км²)
2) Бага нөхөн сэргээгддэг нөөцтэй (5–10 мм/жил/км²)
3) Багаас дундаж нөхөн сэргээгддэг нөөцтэй (10–20 мм/жил/км²)
4) Дундаж нөхөн сэргээгддэг нөөцтэй (20–50 мм/жил/км²)

Error! Reference source not found.-д тулгуурлан хийсэн тооцоогоор Буйр нуур–Халх голын сав газрын нийт 23,443 км² талбайд жилд ойролцоогоор 218 сая м³ газрын доорх ус нөхөн сэргээгдэх боломжтой гэж үзэгдэж байна (**Error! Reference source not found.** харна уу). Үүнээс Нөмрөгийн нурууны орчимд нэг км² талбайд дунджаар 35 мм/жил, нийт 558 км² талбайд жилд 20.0 сая м³ орчим газрын доорх ус нөхөн сэргээгдэх нөөц бүрдэх боломжтой байна.

Халх голын эх болон Азарга голын хөндийг даган тархсан хайрга, чулуужсан хурдсаар бүрдсэн бүсүүдэд нэг км² талбайд дунджаар 15 мм/жил, нийт 5,047 км² талбайд жилд 76 сая м³ орчим газрын доорх ус нөхөн сэргээгдэх боломжтой гэж тооцоологдож байна.


Харин тал хээрийн ховд, говь, намгархаг хотгор бүхий, тогтмол бус тархалттай Плейстоценийн настай аллюви–пролювийн гаралтай хурдсууд, мөн Неогений настай эх газар–газрын нуурын гаралтай, Дээд цэрдийн настай эх газрын нуурын гаралтай хурдсуудын дотор ус агуулга харьцангуй бага, нөхөн сэргэлтийн чадавх сул байна

Пермээс өмнөх насны тунамал чулуулгийн доторх ус агуулга багатай ан цавлаг бүсүүд, мөн янз бүрийн насны түрмэл болон бялхмал чулуулгийн доторх ус агуулга сул ан цавлаг бүсүүдэд хамаарах нийт 15,119 км² талбайд жилд ойролцоогоор 113 сая м³ газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц бүрэлдэх боломжтой гэж тооцоологдлоо[19].



2.7 Амьтны аймаг

Монгол орны зэрлэг амьтны газарзүйн мужлалыг[20] газарзүйн тодорхойлолт[21], ургамлын бүрхэвч[22],[23] хөхтөн амьтдын тархалт[24] зэрэгт үндэслэн бэлтгэдэг. Монгол орны зэрлэг амьтдын газарзүйн бүсчлэлээр Төслийн бүс нь зүүн монголын бүсэд байрладаг:



ЗУРАГ 2-17 МОНГОЛ ОРНЫ АМЬТНЫ ГАЗАРЗҮЙН БҮС НУТГУУД

Хөхтөн

Суурь судалгаа


“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайд тохиолдох боломжтой хөхтөн амьтдын зүйлийн жагсаалтыг боловсруулахдаа Байгаль орчны нэгдсэн мэдээллийн сангийн Амьтны мэдээллийн сан болон Монгол орны Улаан номд бүртгэгдсэн хөхтөн амьтдын тархалтын зургийн мэдээллийг ашигласан. Уг мэдээллүүдийг “Давст-XXXI” талбайн байршилтай газарзүйн мэдээллийн систем (GIS)-ийн аргаар давхардуулан (overlay) шинжилж, Төслийн талбай болон түүний орчимд амьдрах орчны хувьд тохиромжтой, тохиолдох боломжтой зүйлийг тодорхойлсон болно.[25]

Тухайн бүс нутагт нийт 6 багт хамаарах 27 зүйлийн хөхтөн амьтан тохиолдох боломжтой байна. Үүнд туурайтан (Artiodactyla), махчин (Carnivora), туулайтан (Lagomorpha), мэрэгч (Rodentia), шавж идэштэн (Eulipotyphla), сарьсан багваахай (Chiroptera) ангиллууд хамаарна.

Тохиолдох боломжтой зүйлийн дийлэнх нь бүс нутгийн үнэлгээгээр “АӨ – анхааралд өртөхөөргүй” ангилалд хамрагдаж байгаа нь судалгааны бүс нутагт эдгээр амьтдын тархалт өргөн, популяцийн тоо толгой харьцангуй тогтвортой байгааг илтгэнэ. Гэсэн хэдий ч туурайтан ангиллын *Procapra gutturosa* (Цагаан зээр) болон махчин ангиллын *Otocolobus manul* (Мануул) зэрэг зүйлүүд нь бүс нутгийн болон олон улсын түвшинд “Ховордож болзошгүй” ангилалд хамаарах тул Төслийн хэрэгжилтийн явцад эдгээр зүйлүүдийн амьдрах орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг онцгойлон анхаарах шаардлагатай.

Цагаан зээрийн (*Procapra gutturosa*) тархалтын зүй тогтол, амьдрах орчны экологийн шаардлагыг харгалзан үзвэл Төслийн талбай нь уг зүйлийн амьдрах болон шилжилт хөдөлгөөн хийх боломжит нутаг дэвсгэрт хамаарах магадлалтай байна[26]. Цагаан зээр нь тал хээрийн бүсийн задгай, уудам газар нутагт тархах ба өвс, ургамлын бүрэлдэхүүн жигд, хүний үйл ажиллагааны нөлөө харьцангуй бага, саад тотгоргүй орчныг илүүд үздэг нүүдлийн зүйл юм.

Зураг 2-18-т үзүүлсэн бүс нутгийн экологийн нөхцөлөөс харахад Халхгол болон Матад сумын нутаг дэвсгэр нь тал хээрийн хэв шинж сайн хадгалагдсан, бэлчээрийн ургамлын гарц харьцангуй тогтвортой, томоохон суурин, дэд бүтцийн нягтрал бага тул цагаан зээрийн улирлын чанартай шилжилт хөдөлгөөн, хоол тэжээл хайх, түр саатах амьдрах орчинд тохиромжтой бүсэд тооцогдож байна. Иймд Төслийн хэрэгжилтийн явцад уг зүйлийн амьдрах орчин, шилжилт хөдөлгөөний коридорт нөлөөлөх эрсдэл үүсэх боломжтой бөгөөд үүнийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нарийвчлан авч үзэх шаардлагатай юм.



ЗУРАГ 2-18 ЦАГААН ЗЭЭРИЙН БҮС НУТГИЙН ТАРХАЛТ

Шувуу

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайд шувуудын зүйлийн бүрдлийг тодорхойлох зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 22–24-ний өдрүүдэд хээрийн судалгааг гүйцэтгэсэн болно. Судалгаа өвлийн улиралд хийгдсэнтэй холбоотойгоор нүүдлийн болон үржлийн шувуудын идэвхжил багассан, улмаар талбайд ажиглагдсан шувууны зүйл, тоо хязгаарлагдмал байв. Иймд Төслийн талбайд тохиолдох боломжтой шувуудын зүйлийн бүрдлийг илүү бүрэн, бодитой тодорхойлох зорилгоор тухайн бүс нутагт өмнө нь хийгдсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсын сэтгүүлд хэвлэгдсэн судалгааны мэдээллийг суурь эх сурвалж болгон ашиглаж, Төслийн талбайн экологи-газарзүйн нөхцөлтэй дүйцэх орчинд тохиолдох магадлалтай шувуудын жагсаалтыг боловсруулсан болно.

Үүний хүрээнд Дорнод аймгийн шувуудын тархалт, зүйлийн бүрэлдэхүүн, хамгааллын ач холбогдлыг судалсан “Ornithological survey in Dornod province, eastern Mongolia” нэртэй

судалгааны үр дүнг суурь мэдээлэл болгон ашиглав[27]. Тус судалгааг 2015 оны 5 дугаар сарын 29-с 6 дугаар сарын 6-ны хооронд хээрийн нөхцөлд гүйцэтгэж, үр дүнг 2015 онд BirdingASIA сэтгүүлд хэвлүүлсэн байна. Судалгааны гол зорилго нь ховордсон Jankowski's bunting (Emberiza jankowskii) зүйлийн үржлийн тархалтыг илрүүлэх, мөн Дорнод Монголын тал хээр, нойтон бүс, нуур, намаг орчмын шувуудын ерөнхий зүйлийн бүртгэлийг шинэчлэхэд чиглэсэн бөгөөд судалгааны дүнд нийт 165 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Үүнд Сибирь тогоруу (*Grus leucogeranus*), Цэн тогоруу (*Grus vipio*), Хар тогоруу (*Grus monacha*), Идлэг шонхор (*Falco cherrug*) зэрэг IUCN-ын улаан дансанд бүртгэгдсэн, олон улсын хэмжээнд хамгаалал шаардсан зүйлүүд багтсан нь Дорнод аймаг нь шувуудын өндөр ач холбогдол бүхий амьдрах орчин болохыг илтгэж байна.




Figure 2. Map of 2015 survey route in eastern Mongolia showing campsite locations.

Key:
1 Choibalsan
2 Camp site 30 May
3 Camp site 31 May
4 Camp site 1 June
5 Camp site 2 June
6 Khalkhgol
7 Camp site 3 June
8 Camp site 4 June

ЗУРАГ 2-19 ДОРНОД АЙМАГТ 2015 ОНД ХИЙГДСЭН ШУВУУДЫН СУДАЛГААНЫ МАРШРУТ БА АЖИГЛАЛТ ХИЙСЭН БАЙРШИЛ[28]

Дээрх зурагт 2015 оны 5 дугаар сарын 29-с 6 дугаар сарын 6-ны хооронд Дорнод аймагт хийсэн хээрийн судалгааны маршрутыг харуулж, ажиглалтын цэгийн байрлалыг тэмдэглэсэн байна. Судалгааны маршрут нь орон зайн хувьд Төслийн талбайтай давхацсан, гол нуур, намгархаг газар, тал хээрийн экосистемийг хамарсан.

Тус судалгааны тайланд шувуудын ажиглалтын үр дүнг тодорхой харуулах зорилгоор судалгааны явцад ажиглагдсан зарим шувуудын зургийг оруулсан байна. Зурагт материал нь судалгааны үр дүнг баримттай, ойлгомжтой байдлаар илэрхийлэхэд тусалдаг тул бид энэхүү зургийг тайланд мөн ашигласан болно (**Error! Reference source not found.-Error! Reference source not found.** харна уу)[29].

Ургамлан нөмрөг

Энэхүү хэсэгт Зураг 2-20-д үзүүлснээр "Давст-XXXI" газрын тосны хайгуулын талбайн ургамлан нөмрөгийн судалгааг үзүүлсэн болно. "Давст-XXXI" газрын тосны хайгуулын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргийн Дорнод монгол тойрогт хамаарна[30]. Нийт 17 байршилд ургамлын бичиглэл, хэмжилт ургамлын дээж авсан болно.



ЗУРАГ 2-20 УРГАМЛАН НӨМРӨГИЙН СУДАЛГААНЫ БАЙРШИЛ


Ургамлын байршлыг **Error! Reference source not found.**-д үзүүлснээр Монгол орны ургамлын бүлгэмдлийн зураг дээр үндэслэн тодорхойлсон. Ургамлын төрөл зүйлийн суурь нөхцөл, ургамлын зүйлийн бүрдэл, амьдралын хэлбэр, экологийн бүлэг, ургах орчин зэргийг тодорхойлох зорилгоор 17 байршилд ургамлын нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд,

- **Ургамлын зүйлийн бүрдэл:** Хээрийн судалгаагаар Төслийн нөлөөллийн бүсэд 20 овогт хамаарах 47 төрлийн 80 зүйл ургамал бүртгэгдэв (**Error! Reference source not found.** болон **Error! Reference source not found.**-ийг харна уу)
- **Ургамлын амьдралын хэлбэр:** “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайд нийт 80 зүйлийн ургамал тэмдэглэгдсэн бөгөөд 14 зүйлийн нэг наст ургамал (17.5%), 48 зүйлийн олон наст ургамал (60%), 6 зүйлийн сөөглөг ургамал (7.5%), 8 зүйлийн сөөгөнцөр ургамал (10%), 4 зүйлийн булцуу, үндэслэг ургамал (5%) түс түс багтаж байна (**Error! Reference source not found.** болон **Error! Reference source not found.**-ийг харна уу).
- Хээрийн судалгааны үеэр тодорхойлогдсон ургамлын зүйлийн тоог Error! Reference source not found.-д үзүүлсэн бөгөөд ургамлын зүйлийн тоо байршлаас хамааран харилцан адилгүй байна.
- **Хамгааллын статус[31]: Error! Reference source not found.**-т үзүүлснээр Төслийн нөлөөллийн бүсэд бүртгэгдсэн ургамлын зүйлийн дотор IUCN-ийн Улаан номын жагсаалтад хамгааллын статусаар эмзэг, устах аюултай болон нэн ховор ангилалд (VU – Vulnerable, EN – Endangered or CR – critically Endangered) хамаарах ургамал байхгүй.
- **Ургамлын ангилал зүй:** Ангилал зүйн бүлгээр авч үзэхэд ойм хэлбэртэн болон нүцгэн үртний хүрээний ургамал бүртгэгдээгүй бөгөөд 1 зүйл ил үрт ургамал, 21 зүйл нэг талт үрт ургамал, 58 зүйл хос талт үрт ургамал бүртгэгдсэн байна.
- **Ургамлан нөмрөгийн доройтол:** Сулаас дунд хэлбэрийн доройтолд хамаарч байна. **Error! Reference source not found.**-г харна уу.
- **Экологийн бүлэг: Error! Reference source not found.** болон **Error! Reference source not found.**-д үзүүлснээр ургамлын ургах орчныг ус чийгийн хангамж харилцан адилгүй нөхцөлд ургаж буй онцлогоос шалтгаалан экологийн 5 бүлэгт ангилсан. 36 зүйл ургамал нь хуурайд

дасан зохицсон, 24 зүйл нь хуурай-дунд зэргийн чийгсэг, 12 зүйл нь дунд зэргийн чийгсэг, 6 зүйл нь давсархаг, элссэг, 2 зүйл нь чийглэг бичил орчин ангилалд хамаарагдаж байна.

2.9 Тусгай хамгаалалттай газар нутаг


“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн ойролцоо буюу Дорнод аймгийн Матад, Халхгол суманд “Дорнод монгол” дархан цаазат газар, “Нөмрөг” дархан цаазат газрууд нь улсын тусгай хамгаалалтад байна. Гэсэн хэдий ч эдгээр улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь энэхүү Төслийн талбайтай давхцахгүй ба ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн байршлыг Зураг 2-21-д үзүүлэв.



ЗУРАГ 2-21 ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОЙРОЛЦООХ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

“Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн нь Дорнод аймгийн Халхгол, Матад сумын газар нутагт нийт 15,528 км^2 газар нутгийг хамарна. Зураг 2-22-д үзүүлснээр Төслийн талбайн хилд Цондог уул, Дорнод монголын өргөтгөл, Буйр нуур орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд давхцаж байна. Төслийн батлагдсан техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсанаар Төслийн өрөмдлөгийн үйл ажиллагаа орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудад хийгдэхгүй болно.



ЗУРАГ 2-22 ТӨСЛИЙН ТАЛБАЙН ОЙРОЛЦООХ ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Мөн гэсэн хэдий ч 2026 оны 1-р сарын байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санд бүртгэгдсэнээр Дорнод монголын өргөтгөл болон Цондон уул нь 2019 онд орон нутгийн тусгай хамгаалалтаас гарсан[32] байна.

Түүх соёлын өв

“Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 1 дүгээр бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагааны зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагаар археологи, палеонтологийн хайгуул судалгааг хийлгэж холбогдох дүгнэлтийг гаргуулах шаардлагатай.

Төслийн талбайд одоогийн байдлаар илэрсэн түүх, соёлын өвийн мэдээлэл нь доор дурдсан археологийн судалгааны үр дүн, бүртгэгдсэн дурсгалуудад тулгуурлаж байна.

Мезолит → Неолит шилжилт. Төслийн талбай нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах бөгөөд мезолит–неолитын шилжилтийн үеийн эртний хүн амын суурьшил, соёлын хувьслын ул мөр хадгалагдан үлдсэн археологийн дурсгал илрэх боломжтой бүсэд хамаарна. Тухайн бүс нутгийн археологийн дурсгалуудыг анх 1949 онд Дорнод аймгийн Халх гол сумын Тамсаг булаг орчмоос Зөвлөлт–Монголын хамтарсан шинжилгээний экспедицүүд илрүүлсэн бөгөөд 1960-аад оноос эхлэн системтэй археологийн малтлага, судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Тамсаг булаг орчмын археологийн дурсгалт газрууд нь мезолит–неолитын шилжилтийн үеийн (ойролцоогоор МЭӨ VIII–VI мянган жил) хүн амын суурьшил, технологийн хөгжил, амьдралын хэв маягийн өөрчлөлтийг илэрхийлэх чухал баримт мэдээллийг агуулж байна. Тус бүсээс илэрсэн чулуун зэвсгийн микролит технологийн олдворууд, хагас газар доорх сууцны ул мөр, мөн оршуулгын шинжтэй дурсгалууд нь ан агнуурт суурилсан нүүдлийн хэв маягаас илүү тогтвортой суурин амьдралд шилжих эхэн үеийг тодорхой харуулж байна.

Эдгээр археологийн олдворууд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт неолитжих (neolithisation) үйл явц хэрхэн явагдсан талаар шинжлэх ухааны өндөр ач холбогдолтойд тооцогддог бөгөөд тухайн бүс нутгийг соёлын өвийн хувьд мэдрэг ангилалд хамааруулан авч үзэх шаардлагатайг илтгэнэ[33].



Fig. 1. Tamsgbulag 1. Trench A seen from the South. Spring ("bulag" in Mongolian) at the foot of the terrace (12m high); the marshy area and the soviet built milatary road through the ancient lake; on the background, the opposite terraces (Tamsagbulag 2) and the steppe.




Fig. 13. Tamsagbulag 1. Types of graves discovered beneath the house floors (after Okladnikov and Derevianko 1970*).*

ЗУРАГ 2-23 СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ ДАХ ЗУРГААС[34]

АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

Тус лицензийн талбайд түүх, археологийн дурсгалт өвийг илрүүлэх, бүртгэх, хамгаалах зорилгоор анх 2010 онд "Петрочайна Дачин Тамсаг Монгол" ХХК-ийн захиалгаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн Хайгуул судалгааны экспедиц археологийн урьдчилсан болон авран хамгаалах хайгуул судалгааг гүйцэтгэсэн байна. Судалгааны ажлыг 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлүүлэн доктор Ч.Ерөөл-Эрдэнэ, доктор Г.Эрэгзэн, докторант Ц.Болорбат, магистр П.Алдармөнх нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэсэн бөгөөд илэрсэн дурсгал тус бүрийн байршлыг GPS багажаар тогтоож, холбогдох баримтжуулалтыг хийсэн байна. Тус судалгааны тайланг энэхүү тайлангийн хавсралтад оруулав.

Илэрсэн археологийн дурсгалын ерөнхий төлөв

Хайгуул судалгааны үр дүнд лицензийн талбайн хүрээнд нийт 160 гаруй археологийн дурсгал илрүүлэн бүртгэсэн байна. Эдгээр дурсгал нь Монгол орны түүх, соёлын хөгжлийн олон үеийг хамрах бөгөөд үндсэндээ дараах төрөлд хамаарна. Үүнд:

- Чулуун зэвсгийн үеийн бууц, суурин, оршуулгын дурсгал болон түүвэр олдвор;
- Хүрэл зэвсгийн үе болон төмөр зэвсгийн түрүү үеийн дөрвөлжин, дугуй хэлбэрийн булш, оршуулгын байгууламж;
- Хүннү болон Түрэгийн үеийн булш, оршуулгын дурсгал;
- Дундад зууны үед холбогдох хүн чулуун хөшөө;
- XVIII–XIX зууны үед холбогдох бурхны шашны сүм хийдийн туурь, суварга болон бурхны чулуун хөрөг зэрэг болно.

Онцлон тэмдэглэвэл зохих археологи, түүхийн дурсгалууд

[34] https://journals.uni-lj.si/DocumentaPraehistorica/article/view/31.10/1894

Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн үеийн (неолитын) бууц, суурин – Одоогоос 7–6 мянган жилийн өмнөх үед холбогдох бөгөөд Монгол орны чулуун зэвсгийн үеийн хүний сууц, суурьшил, оршуулгын зан үйлийг судлахад чухал ач холбогдол бүхий дурсгал юм. Уг дурсгал нь Халхгол сумын нутагт оршино.
Бүрдийн оршуулгын дурсгалт газар – Хөх Бүрдний голын сав газарт орших бөгөөд хүрэл зэвсгийн үе болон төмөр зэвсгийн түрүү үед холбогдох нийт 158 булш бүхий томоохон оршуулгын цогцолбор юм. Тус дурсгал нь Матад сумын нутагт байрладаг.
Шонх таван толгойн хүн чулуу – XIII зууны Монголын язгууртны үеийн түүх, соёлын чухал өвд тооцогдох хүн чулуун хөшөө бөгөөд Халхгол сумын нутагт оршино.
Их Бурхант – 1859–1864 онд бүтээн байгуулсан бурхны шашны холбогдолтой түүх, соёлын дурсгалт цогцолбор бөгөөд суварга болон бурханы чулуун хөрөг зэрэг дурсгалуудыг агуулдаг. Уг дурсгал нь Халхгол сумын нутагт байрладаг.[35]

2.10 Нийгэм, эдийн засаг

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК нь буй “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн төслийг хэрэгжүүлж байна. “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбай нь Монгол орны зүүн хэсэгт, Дорнод аймгийн Матад, Халхгол сумдын нутагт, Улаанбаатар хотоос зүүн зүгт шулуунаар 650-800 км, Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотоос зүүн-зүүн хойш 150-330 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн-зүүн урагш 100-260 км зайд оршино (зайг илтгэх эхний тоо нь тухайн суурин газарт хамгийн ойр хилийг, харин дараагийн тоо нь хамгийн алслагдсан хилийг илтгэнэ). “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн хойд хэсэг нь Матад сумын Мэнэн баг, төв хэсэг нь Буян-Өндөр баг, өмнөд хэсэг нь Эрдэнэбадрах баг, баруун өмнөд булан нь Түмэнхаан баг, зүүн хэсэг нь Халхгол сумын Ялалт баг, зүүн өмнөд булан нь Ташгай багийн нутагт хамаарна. Төслийн талбайн засаг захиргааны нэгжийн байршлыг Зураг 2-24-д харуулав.



ЗУРАГ 2-24 ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

3.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шалгуур үнэлгээгээр Төслийн хуримтлагдах нөлөөлөл хамааралтай гэж тодорхойлсны дагуу энэхүү хэсэгт Төслийн үйл ажиллагааг тухайн бүс нутагт хэрэгжсэн, хэрэгжиж буй болон хэрэгжихээр төлөвлөж буй бусад төсөл, үйл ажиллагаатай хамтад нь авч үзэн, байгаль орчны үнэт бүрэлдэхүүн (ҮБ)-д үзүүлэх нэгдсэн (хуримтлагдах) нөлөөллийг үнэлэв.

ХҮСНЭГТ 3-1 ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэт бүрэлдэхүүн	Хуримтлагдах нөлөө үзүүлэх эх үүсвэр	Хуримтлагдах нөлөөлөл	Ач холбогдол	Менежментийн арга хэмжээ
Агаарын чанар	Тус төсөл + Тамсаг-XXI + бүс нутгийн тээвэр	Нийтлэг зам дагуух тоосжилт, шаталтын ялгаралт нэмэгдэх	Дунд	Тоосжилт дарах ажлыг зэргэлдээ эзэмшигчтэй уялдуулах, нийтлэг замын менежмент, хамтарсан мониторинг
Гадаргын ус (Халх гол, Буйр нуур)	Тус төсөл + хуучин цооногийн нэвчилт + сав газрын ус ашиглалт	Рамсарын сав газрын усны чанар, горимд хуримтлагдах дарамт	Өндөр	Асгаралтаас чандлан сэргийлэх, Халх голд шууд гаргалгаагүй байх, сав газрын түвшний мониторинг, хамтын ажиллагаа
Газрын доорх ус	69 хуучин + 16 шинэ + Тамсаг-XXI цооног	Ус агуулагч давхаргыг олон цооног нэвтэлж бохирдол, түвшний өөрчлөлт хуримтлагдах	Дунд–Өндөр	Цооногийн битүүмжлэлийн бүрэн бүтэн байдал, хуучин цооногийн LDAR, бүс нутгийн усны мониторинг
Хөрс, бэлчээр	Тус төсөл + зэргэлдээ талбай + зам, дэд бүтэц	Олон талбайн ажлын байр, зам, кемпийн нийлбэр эвдрэл, бэлчээр алдагдал	Дунд	Ул мөрийг багасгах, дэд бүтэц хуваалцах, үе шаттай нөхөн сэргээлт
Биологийн олон янз байдал (цагаан зээр)	Тус төсөл + Тамсаг-XXI + зам, хашаа, төмөр зам	Олон талбай, шугаман дэд бүтцээс амьдрах орчин хуваагдаж, нүүдлийн замд саад тотгор нэмэгдэх	Өндөр	Нүүдэлд ээлтэй хийц (хашаа буулгах, коридор хамгаалах), улирлын хязгаарлалт, зэргэлдээ эзэмшигчтэй нэгдсэн орон зайн төлөвлөлт
Хүлэмжийн хий, уур амьсгал	Тус төсөл + бүс нутгийн бүх талбайн ялгарал	Бүс нутгийн нэгдсэн хүлэмжийн хийн ул мөр	Дунд	Хийн шаталт бууруулах, хуучин цооногийн метан алдагдлыг засах (LDAR), ялгарлыг бүртгэх

ХҮСНЭГТ 3-2 ХИЛ ДАМНАСАН НӨЛӨӨЛЛИЙН ЗАМНАЛ, ҮНЭЛГЭЭ

Нөлөөллийн зүйл	Нөлөөллийн замнал	Хил дамнасан үр дагавар	Суурь	Үлдэгдэл	Бууруулах арга хэмжээ
Усны бохирдол	Халх голд тос, химийн бодис, хаягдал ус нэвчих	Урсгал доошоо Буйр нуур хүртэл, улмаар хил дамнан тархах	Өндөр	Дунд	Халх голд шууд гаргалгаагүй байх, буфер бүс, асгаралтаас сэргийлэх, сав газрын мониторинг

Нөлөөллийн зүйл	Нөлөөллийн замнал	Хил дамнасан үр дагавар	Суурь	Үлдэгдэл	Бууруулах арга хэмжээ
Намгархаг газрын экосистем (Буйр нуур, Рамсар)	Усны чанар, түвшний өөрчлөлт, бохирдол	Хуваалцсан экосистем, нүүдлийн шувууны амьдрах орчинд нөлөөлөх	Өндөр	Дунд	Урьдчилан сэргийлэх зарчим, Рамсарын шаардлага баримтлах, түвшний хяналт
Нүүдлийн зүйл (цагаан зээр, нүүдлийн шувуу)	Амьдрах орчны хуваагдал, үймээн	Монгол–БНХАУ хил дамнасан нүүдэл, үржилд саад учруулах	Дунд	Бага	Нүүдэлд ээлтэй хийц, улирлын хязгаарлалт, коридор хамгаалах
Агаарын нөлөө	Тоос, шаталтын ялгаралт	70 км зайд хил дамнан тархах магадлал бага	Бага	Бага	Тоосжилт дарах, ялгарал бууруулах

3.1 Нөлөөллийн үнэлгээний гол үр дүн

Нөлөөллийн үнэлгээг өртөгчийн өртөнги байдал болон нөлөөллийн цар хүрээний уялдаанд харгалзан, байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр гүйцэтгэв. Бүрэлдэхүүн тус бүрд үзүүлэх нөлөөллийн ач холбогдлын нэгдсэн үнэлгээг Хүснэгт 3-3-т үзүүлэв.

ХҮСНЭГТ 3-3 БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЧ ХОЛБОГДЛЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

Бүрэлдэхүүн	Нөлөөллийн гол эх үүсвэр	Ач холбогдол	Бууруулах гол арга хэмжээ
Уур амьсгал (хүлэмжийн хий)	Дизель шаталт, хийн шатаалт, метан нэвчилт	Бага–Дунд	Хийн шатаалт бууруулах, LDAR, ялгарал бүртгэх
Агаарын чанар	Тоосжилт, шаталтын ялгаралт	Бага–Дунд	Тоос дарах, ялгарал хянах, мониторинг
Хөрсөн бүрхэвч	Газар шорооны ажил, асгаралт, хаягдал	Дунд	Ул мөр багасгах, шимт хөрс хадгалах, нөхөн сэргээлт
Усны нөөц (гадаргын, гүний)	Асгаралт, хаягдал ус, өрөмдлөг	Дунд–Өндөр	Асгаралтаас сэргийлэх, битүүмжлэл, сав газрын мониторинг
Биологийн олон янз байдал	Амьдрах орчин хуваагдах, цагаан зээрийн нүүдэлд саад	Өндөр	Нүүдэлд ээлтэй хийц, улирлын хязгаарлалт, коридор хамгаалах
Дуу чимээ	Өрөмдлөг, сейсм, тээвэр	Бага–Дунд	Тоног төхөөрөмжийн хяналт, зайн менежмент
Хог хаягдал	Өрмийн зүсмэл, шингэн, ахуйн хаягдал	Дунд	Аюултай хаягдлын зохистой менежмент, тусгаарлалт
Цацраг идэвх	Каротаж, NORM	Бага	Битүүмжилсэн хадгалалт, цацрагийн хяналт
ТХГ, соёлын өв	Газар шорооны ажил	Бага	Санамсаргүй олдворын журам, буфер бүс
Нийгэм, эдийн засаг	Ажил эрхлэлт, бэлчээр/усны ашиглалт	Эерэг ба Дунд	Орон нутгийн ажил эрхлэлт, санал гомдлын механизм

3.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн (БОНБҮтХ) 9.1 дүгээр зүйлд заасны дагуу “Давст-XXXI” газрын тосны хайгуулын талбайн төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, мөн болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг нь төслийг хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-д ногдож байна.

Иймд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-д заасны дагуу уг Төслийн үйл ажиллагаанд мөрдөх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

БОНБҮтХ-ийн 9.5 дугаар зүйлд зааснаар БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ) болон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнээс БХТ-д байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тодорхойлон тусгасан болно (БОНБҮтХ-ийн 9.6 дугаар зүйл). Харин ОХШХ-д Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд гарч буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, хугацаа, шаардагдах зардлыг тусгасан болно (БОНБҮтХ-ийн 9.7 дугаар зүйл).

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) нь Төслийн БОМТ-г баталж, хэрэгжилтэд хяналт тавих, жил бүрийн тайланг үндэслэн дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохицуулна.

2	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай хууль	6 дугаар зүйл. Төлөв байдлын болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ	6.1.Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 3.1.4-т заасан үнэлгээг хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна. 6.2.Төлөв байдлын үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулна. 6.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлд энэ хуулийн 3.1.5-д заасан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийнэ.

			6.5.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулна.
		7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ	7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ. 7.3.Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.
		13 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн эрх	13.1.1.стратегийн болон нөлөөллийн үнэлгээ хийлгэх хүсэлтээ эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжид тавих; 13.1.2.төлөв байдлын, стратегийн болон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх аж ахуйн нэгжийг сонгох; 13.1.3.тухайн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн техник, технологи, бизнесийн холбоотой зарим шаардлагатай мэдээллийг нууцлахыг стратегийн болон нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх аж ахуйн нэгжээс шаардах.
		20 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх	20.1.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэлгүйгээр төслийг хэрэгжүүлснээс буюу үнэлгээгээр тавигдсан шаардлагыг зөрчсөний улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан аргачлалын дагуу тооцож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ. 20.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг буруу хийснээс байгаль орчинд учруулсан хохирлыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлнэ.
3	Агаарын тухай хууль	9 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг	9.1.1.агаарын хууль тогтоомж, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, Засаг даргын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх; 9.1.2.агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах; 9.1.3.агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох; 9.1.4.аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах; 9.1.5.аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх; 9.1.6.агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах; 9.1.7.агаарын бохирдлыг бууруулах талаарх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх; 9.1.8.агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх;

			9.1.9.агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах; 9.1.10.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа нь агаар бохирдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн бол холбогдох байгууллагад шаардлага тавих, гомдол мэдүүлэх, мэдэгдэх; 9.1.11.хуульд заасан бусад эрх, үүрэг.
		16 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хориглох зүйл	16.1.1.зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах; 16.1.2.агаар бохирдуулах бодис ялгаруулдаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх; 16.1.3.энэ хуулийн 6.1.6-д заасан урамшуулал бүхий цахилгаан эрчим хүчийг ахуйн зориулалтаас бусад хэлбэрээр ашиглах; 16.1.4.стандартын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл ашиглах; 16.1.5.түүхийн нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаах.
		18 дугаар зүйл. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл	18.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна. 18.2.Энэ хуулийн 18.1-д заасан зөвшөөрөлд тухайн эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдал, үзүүлэх физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг зааж, агаар хамгаалах талаар авах арга хэмжээ, хууль тогтоомжид заасан бусад шаардлагыг тусгана.
4	Усны тухай хууль	6 дугаар зүйл. Усны хяналт-шинжилгээний сүлжээ	6.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна. 6.2.Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ байнгын ажиллагаатай дараах хэсгээс бүрдэнэ: 6.2.1.улсын хяналт-шинжилгээний сүлжээ; 6.2.2.сав газрын хяналт-шинжилгээний нэгж; 6.2.3.аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын цэг. 6.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усны хяналт-шинжилгээний хөтөлбөр, усны шинжилгээний аргачлалыг баталж, мэргэжлийн удирдлагаар хангах бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрт усны сан бүхий газар, газрын доорх усны ордын нэр, хяналт-шинжилгээний харуул, өртөө, цооногийн тоо, байршил, шинжилгээний төрөл, арга зүй, хариуцан гүйцэтгэгчийг тус тус заана.
		22 дугаар зүйл. Усны нөөцийг хамгаалах	22.1.Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно. 22.2.Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно. 22.2.1.Онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

			22.3.Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно. 22.4.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд энэ журмаар онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, бүсэд мөрдөх дэглэмийг тогтооно. 22.6.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 22.4-т заасан дэглэм зөрчихийг хориглоно.
		24 дүгээр зүйл. Усны нөөцийг бохирдохоос хамгаалах	24.1.Усны сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, бохир ус хаях, хадгалах, машин техник, бохир зүйлс угаахыг хориглоно. 24.4.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулсан байна. 24.5.Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг усны мэдээллийн санд бүртгэнэ. 24.6.Хаягдал ус зайлуулах зөвшөөрөлд заасан хэмжээнээс болон хаягдал усны стандартаас хэтэрсэн бохир усыг удаа дараа хаясан нь ус ашиглах эрхийг цуцлах үндэслэл болно. 24.7.Энэ хуулийн 24.2-т заасан хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийн загварыг байгаль орчны болон хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
		28 дугаар зүйл. Ус ашиглагчид олгох зөвшөөрөл	28.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ энэ хуулийн 28.4-т заасан этгээдэд гаргана. 28.2.Ус ашиглах хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана: 28.2.1.Ашиглах усны эх үүсвэр, эсхүл рашааны эх булаг, түүний байршлыг харуулсан зураг; 28.2.2.Ус, рашааны нөөц, чанар, найрлагыг тогтоосон хайгуул, судалгааны тайлан, ашиглах боломжит нөөцийн талаарх дүгнэлт; 28.2.3.Хоногт ашиглах усны хэмжээ, зориулалт; 28.2.4.Барилга байгууламжийн зураг, төсөл; 28.2.5.Үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт; 28.2.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт. 28.4.Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана. 28.5.Энэ хуулийн 28.4-т заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана. 28.6.Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

			28.7.Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна. 28.8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах зөвшөөрлийг 10 хүртэл жилийн хугацаагаар олгож, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ирсэн ус ашиглагчийн эрхийг тухай бүр 5 хүртэл жилээр сунгана. 28.9.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах зориулалт бүхий ус ашиглах зөвшөөрлийн хугацаа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна. 28.10.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрх нь өөрийн эзэмшлийн газар дахь ус ашиглах эрхийг төлөөлөхгүй. 28.11.Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ. 28.12.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны нөөцийг гэрээний үндсэн дээр хамтран ашиглаж болно. 28.13.Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон усны нөөцийг ашиглах тохиолдолд усны эрэл, хайгуул, судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлнэ. 28.14.Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглалтын нөөцийн баталгаажуулсан хэмжээ нь зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн хэрэгжүүлэх төслийн үргэлжлэх хугацаа болон ашигтай ажиллах нөхцөлийг хангахаар байгаа тохиолдолд ус ашиглах эрхийг бусад аж ахуйн нэгжид давхардуулан олгохгүй. 28.15.Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглах боломжит нөөц нь тухайн хэрэгжүүлэх төслийн усны хэрэгцээг бүрэн хангаж, илүү гарах нөхцөлд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бусад аж ахуйн нэгжийн хэрэгцээнд ашиглуулах бөгөөд усны эрэл, хайгуулын нийт зардлаас зөвхөн тухайн аж ахуйн нэгжид нийлүүлэх усны эрэл, хайгуулын ажилд зарцуулсан зардлыг нөхөн төлүүлж болно. 28.16.Энэ хуулийн 28.14, 28.15 дахь хэсэг нь унд, ахуйн болон байгаль хамгааллын зориулалтаар ашиглах усны харилцаанд хамаарахгүй. 28.17.Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 28.18.Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно. 28.19.Байгальд халтай технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулах дүгнэлт гаргахыг хориглоно.
		29 дүгээр зүйл. Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах	29.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан ус ашиглах гэрээг дараах тохиолдолд зөвшөөрөл олгогчийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцална: 29.3.1.Ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй; 29.3.2.байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн; 29.3.3.Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй; 29.3.4.Усны эх үүсвэрийг бохирдуулсан; 29.3.5.Усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

			29.3.6.Сав газрын захиргааны шийдвэрээр. 29.4.Хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн усны эх үүсвэрээс ашиглаж байгаа бусад ус ашиглагчийн эрхийг төр өөрийн санаачилгаар цуцалж болно.
5	Байгалийн ургамлын тухай хууль	7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах	1.Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. 2.Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулах, нутагшуулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. 3.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох журмыг хуулиар тогтооно. 4.Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид *төрийн захиргааны төв байгууллага* гэх/-ын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно. 5.Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамал хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхийг хориглоно. 6.Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглоно. 7.Харь ургамлыг байгальд тарималжуулахад зориулалтын хязгаарлаж битүүмжилсэн талбайг ашиглана.
	Амьтны тухай хууль	6 дугаар зүйл. Амьтныг хамгаалах хэлбэр	6.1.Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална: 6.1.1.Амьтныг ашиглахад хорио, хязгаарлалт тогтоох; 6.1.2.Нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын "Улаан ном", бусад холбогдох гэрээ, конвенцын хавсралтад бүртгэх; 6.1.3.Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.4.Амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах; 6.1.5.Амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах; 6.1.6.Амьтныг сэргээн нутагшуулах; 6.1.7.Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх; 6.1.8.Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх; 6.1.9.Өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах; 6.1.10.Амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх; 6.1.11.Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах 6.2.Энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7- 6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.
		7 дугаар зүйл. Нэн ховор, ховор	7.1.Нэн ховор амьтанд Мазаалай баавгай /Ursus arctos gobiensis/, Хавтгай тэмээ /Camelus bactrianus ferus/, Тахь адуу /Equus ferus przewalskii/, Ойн буган цаа /Rangifer tarandus/, Цоохор ирвэс /Uncia uncial/, Баданга хүдэр /Moshus moshiferus/, Молцог хандгай /Alces alces/, Татаар бөхөн /Saiga tatarica/, Голын халиу /Lutra

		амьтныг хамгаалах	lutra/, Азийн минж /Castor fiber/, Ойн унтаахай /Dryomos nitedula/, Зүүн гарын даахай /Stylodipus sungorus/, Борцгор хотон /Pelicanus crispus/, Хургач бор /Paradoxornis heudei/, Цагаан тогоруу /Grus leucogeranus/, Хар мөрний хилим /Acipenser schrenckii/, Шаргал үхэрдэй /Tinca tinca/, Цөөвөр чоно /Cuon alpinus/, Шивэр молцог хандгай /Alces alces pfizenmayeri/, Дорнын молцог хандгай /Alces alces cameloides/, Соргог бөхөн /Saiga tatarica/, Монгол бөхөн /Saiga borealis/,Алтайн чацуулин /Talpa altaica/, Гозоорой зурам /Citellus alaschanicus/, Сухайн чичүүл /Meriones tamariscinus/, Давжаа алагдаага /Allactaga elater/, Цагаантолгойт ямаансүүл /Oxyura leucocephala/, Могойч загалай /Circaetus gallicus/, Бор бүргэд /Aguilla clanga/, Усны нөмрөгбүргэд /Aguila clanga/, Реликт цахлай /Larus relictus/ зэрэг амьтан хамаарна. 7.2.Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно. 7.3.Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно. 7.4.Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ. 7.5.Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр ховор амьтныг дараах тохиолдолд агнаж, барьж болно: 7.5.1.Судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар; 7.5.2. Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн; 7.5.3.Тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор. 7.6.Ховор амьтны жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.
		37 дугаар зүйл. Амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх	37.1.Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ. 37.2.Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж тогтооно. 37.3.Энэ хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан, гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн зүйл ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна. 37.4.Ан амьтан агнах эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, түүнчлэн зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.
7	Хөрс хамгаалах цөлжилтөөс хамгаалах тухай хууль	9 дүгээр зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг	9.1.Хөрсийг доройтуулж, цөлжилт үүсэх нөхцөл бүрдүүлсэн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, хөрсний бохирдлыг арилгах, нөхөн сэргээх түүнд хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий албан тушаалтнаас шаардах; 9.2.Хөрсний доройтол, цөлжилтийн талаар үнэн зөв мэдээллийг эрх бүхий байгууллагаас авах, өгөх; 9.3.Өөрийн хууль бус үйл ажиллагаанаас хөрсийг доройтуулсан бол хохирлыг арилгаж, хөрсийг нөхөн сэргээх. 9.4.Энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
		11 дүгээр зүйл. Хөрсний	11.1.Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, дүгнэлтийг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

		доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа	11.2.Хөрсний шинж чанарт гарч байгаа өөрчлөлтийг итгэмжлэгдсэн хөрсний лаборатори тогтооно. 11.3.Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаанд дараах үйл ажиллагааг хамааруулна: 11.3.1.Хөрсний доройтол, цөлжилт үүсгэж байгаа шалтгаан, эх үүсвэрийг тогтоох; 11.3.2.Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын зэрэглэл, тархалтын хүрээг тогтоох; 11.3.3.Хөрсний шинж чанарыг тогтоох; 11.3.4.Шууд болон шууд бус хохирлыг тогтоох; 11.3.5.Доройтолд орсон хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох; 11.3.6.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг төлөвлөх: а/Хөрс хамгаалах, нөхөн сэргээх; б/Цөлжилтөөс сэргийлэх; в/Цөлжилтийг сааруулах; г/Цөлжилттэй тэмцэх. 11.4.Хөрсөнд учруулсан хохирлын хэмжээг тогтоох үйл ажиллагааны зардлыг тухайн газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж, байгууллага өөрөө хариуцах бөгөөд нийтийн эзэмшлийн газрын хөрсөнд учруулсан хохирлын хэмжээг тогтоох үйл ажиллагааны зардлыг тухайн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.
		12 дугаар зүйл. Хөрсөнд учруулсан хохирлын нөхөн төлбөр	12.1.Хөрсөнд доройтол учруулсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны хяналтын улсын байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наймаас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина. 12.2.Гэм буруутай этгээд нөхөн төлбөр төлсөн нь түүнийг Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
8	Хог хаягдлын тухай хууль	10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг	10.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх эдэлнэ: 10.1.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах; 10.1.2.Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах. 10.2.Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ: 10.2.1.Энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах; 10.2.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх; 10.2.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах; 10.2.4.Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх; 10.2.5.Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх; 10.2.6.Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох; 10.2.7.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх; 10.2.8.Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх; 10.2.9.Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх; 10.2.10.Энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;

			10.2.11.Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах; 10.2.12.Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх; 10.2.13.Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах; 10.2.14.Хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах; 10.2.15.Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх; 10.2.16.Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх; 10.2.17.Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх; 10.2.18.Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах. 10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно: 10.3.1.Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях; 10.3.2.нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях; 10.3.3.Хог хаягдлыг ил задгай шатаах; 10.3.4.Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах; 10.3.5.Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях; 10.3.6.Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах; 10.3.7.Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.
9		14 дүгээр зүйл. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх	14.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна. 14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ. 14.3.Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно. 14.4.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө. 14.5.Энэ хуулийн 14.4-т заасан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө. 14.6.Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

			14.7.Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана. 14.8.Энэ хуулийн 14.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЛТАНШИРЭЭ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ДАВСТ XXXI ТАЛБАЙД ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ ХИЙХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

Улаанбаатар
2026 он

ХАВСРАЛТ 1. АЖ АХУЙН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

00017706 1

2017.04.25
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011671052
/ Хувийн хэргийн дугаар /

6177492
/ Регистрийн дугаар /

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол 108 2017.04.04
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

8299 "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 10,000.0
/ хугацаа / / гишүүдийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, бага тойруу, Сүхбаатарын талбай гудамж 8/1 байр 1601 тоот, Утас1: 88097340, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 12 сар 20 өдөр

ХАВСРАЛТ 2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАР



МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

201 9 оны 08 сарын 08 өдөр Дугаар 371 Улаанбаатар хот

Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Сүхбаатарын талбай гудамж, 8/1 байр, 1601 тоот
Регистрийн дугаар	6177492
Тусгай зөвшөөрлийн хугацаа	8 /найм/ жил
Тусгай нөхцөл, шаардлага	

Холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ биелүүлж ажиллах.

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 201 9 оны 08 сарын 08 өдрийн A/166 дугаар тушаалыг үндэслэн олгов.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД Д.СУМЪЯАБАЗАР

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

ХАВСРАЛТ 3. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011671052
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	“Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төсөл хэрэгжүүлэх
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-3, Бодь цамхаг, 900 тоот
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д. Алтанцэцэг, 9909-9263 altantsetseg.d@mongolrefiney.mn
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Мандахцацрал, 99878494 mandakhtsatsral.d@mongolrefinery.mn
3.2	1. Төслийн нэр	Газрын тос боловсруулах үйлдвэр барих
	2. Төслийн харъяаллын байршил	Дорноговь аймгийн Алтанширээ сумын 6-р баг
	3. Төслийн ангилал	
	а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт	Хамааралгүй
	б. ил уурхай, далд уурхай, шороон орд	Хамааралгүй
	в. баяжуулах үйлдвэр	Газрын тос боловсруулах үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2017
	5. Төсөл хэрэгжих хугацаа	
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	Хамааралгүй
	7. Хаалтын дараах зориулалт	Хамааралгүй
	8. ТЭЗҮ баталсан огноо	2018.11.16
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	Хамааралгүй
	10. Ажилчдын тоо	81
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	Газрын тосны үйлдвэрийн багц ажлууд EPC-2: Анхдагч процессын болон дагалдах байгууламж, EPC-3: Үйлдвэрийн цахилгаан станц, EPC-4: Лицензтэй технологийн байгууламж, Түүхий тос дамжуулах хоолойн барих ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
	12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	
	• замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл	17,5 км хүнд даацын авто зам 27 км төмөр зам
	• шатахуун түгээгүүрийн тоо	
	• шатахууны агуулахын агууламжийн хэмжээ	
	• тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	

ХАВСРАЛТ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Мэдээллийн төрөл		Мэдээлэл оруулах багана	
4.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай		Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх №371 2027.08.08 408 га	
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа		Химийн бодис ашиглахгүй.	
	3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт		Хамааралгүй.	
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар		Хамааралгүй	
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн шинээр баригдах салбар төмөр зам–БОАЖЯ-2018.08.06 2. Газрын тос боловсруулах үйлдвэр, үйлдвэрийн усны эх үүсвэр ба ус хангамжийн шугам хоолой барих төсөл-БОАЖЯ-2019.07.30 3. Газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолой барих төсөл-БОАЖЯ-2020.06.22	
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		1.Газрын тос боловсруулах үйлдвэрийн шинээр баригдах салбар төмөр замын БОННҮ–БОАЖЯ-2018 2.Газрын тос боловсруулах үйлдвэр, үйлдвэрийн усны эх үүсвэр ба ус хангамжийн шугам хоолой барих төслийн БОННҮ-БОАЖЯ-2020.01.23 3. Түүхий тос дамжуулах хоолойн БОННҮнэлгээ 2024.02.16	
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо		2026.05	
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо			
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах			
	10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн	
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх	
		Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн	
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх	
	11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах			

ХАВСРАЛТ 5. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
5.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Химийн бодис ашиглахгүй.
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө - урьдчилан сэргийлэх арга хэмжээ - эрсдлийн үед авах арга хэмжээ - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй.
5.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Хамааралгүй.
5.3	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал	Барилга-угсралтын гүйцэтгэгч компаниуд хариуцна.
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Барилга-угсралтын гүйцэтгэгч компаниуд хариуцна.

ХАВСРАЛТ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
6.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	-
	2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	-
	3. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
	4. Түүх соёлын өвийн хамгаалах төлөвлөгөө	-
	5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	-
	6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	Ажилчдын томиолотын зардлаар тооцно
	8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	-
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	-

ХАВСРАЛТ 7. МЕТА МЭДЭЭЛЭЛ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
5.1	2. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Химийн бодис ашиглахгүй.
	3. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө - урьдчилан сэргийлэх арга хэмжээ - эрсдлийн үед авах арга хэмжээ - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй.
5.2	3. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 4. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Хамааралгүй.
5.3	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал	Барилга-угсралтын гүйцэтгэгч компаниуд хариуцна.
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Барилга-угсралтын гүйцэтгэгч компаниуд хариуцна.

ХАВСРАЛТ 8. ТУХАЙ ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
7.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	
	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

ХАВСРАЛТ 9. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

Нөлөөллийн ангилал	А.Тооцсон эсэх	Б.Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В.Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г.Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт

1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Эвдэх • Дороитуулах	Тооцсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	
2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Нөөцийг бууруулах	Тооцсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	
3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл • амьдрах орчинг хуваах • амьдрах орчинг дороитуулах • амьдрах орчинг хомсдуулах • нөөцийг бууруулах	Тооцсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	
4. Агаарт үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • тоос	Тооцсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	
5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс • Хамгаалах • Нүүлгэн шилжүүлэх	Тооцсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	Тодорхойлсон.	

ХАВСРАЛТ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
9.1 Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	14	Тодорхойлсон	Тодорхойлсон	
9.2 Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	14	Тодорхойлсон	Тодорхойлсон	
9.3 Нөхөн сэргээлтийн арга хэмжээ • техникийн/ га эзэлхүүн • биологийн /га	2	Тодорхойлсон	Тодорхойлсон	
9.4 Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	-	Тодорхойлсон	Тодорхойлсон	
9.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	6	Тодорхойлсон	Тодорхойлсон	

ХАВСРАЛТ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН АНГИЛАЛ

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж (удаа)	Г. Төсөв (төг)
1. Хөрс	12	Газрын тосны үйлдвэрийн хотхон, үйлдвэрийн авто зам болон төмөр зам	2	
2. Ус	4	Газрын тосны үйлдвэрийн хотхон, үйлдвэрийн талбай	2	

3. Амьтан		Газрын тосны үйлдвэрийн хотхон, үйлдвэрийн талбай	2	
4. Ургамал	30	Газрын тосны үйлдвэрийн хотхон, үйлдвэрийн авто зам болон төмөр зам	2	
5. Агаар	24	Газрын тосны үйлдвэрийн хотхон, үйлдвэрийн авто зам болон төмөр зам	2	